

**Монгол Улсын Татварын Ерөнхий газар**

**МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБАНЫ  
ТАТВАР ХУРААЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА  
БОЛОН ОЛОН УЛСЫН ТАТВАРЫН  
АСУУДЛЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ  
ТӨСЛИЙН 2-Р ШАТ**

**Эцсийн тайлан**

**2020 оны 3 сар**

**ЯПОНЫ ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ  
БАЙГУУЛЛАГА (JICA)**

**Санхүү, төсвийн судалгааны институт**

**Пакса ХХК**

<b>IL</b>
<b>JR</b>
<b>20-011</b>

## ГАРЧИГ

<b>1. Төслийн танилцуулга</b> .....	1
1.1 Өмнөх үг .....	1
1.2 Монгол Улсын татварын удирдлагын орчин .....	1
1.3 Төсөл хэрэгжүүлэх бүтэц бүрэлдэхүүн .....	3
<b>2. Төслийн агуулга</b> .....	6
2.1 Төслийн эрхэм зорилго .....	6
2.2 Төслийн зорилго .....	6
2.3 Төслийн зорилго, зорилтын биелэлтийн байдал .....	6
2.4 Үйл ажиллагааны зорилго .....	19
2.5 Төслийн хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа.....	19
<b>3. Төслийн зорилго, зорилтын биелэлтийн байдал</b> .....	29
3.1 Төсөл хэрэгжүүлэх зохист байдал .....	29
3.2 Төслийн үр ашиг .....	30
3.3 Төслийн үр дүнтэй байдал .....	35
3.4 Төслийн нөлөөлөл .....	35
3.5 Тогтвортой байдал .....	37
3.6 Төслийн үр нөлөөнд нөлөөлсөн хүчин зүйлс .....	38
<b>4. Төслийн хэрэгжилттэй холбоотой шийдвэрлэх асуудлууд ба сургамж</b> .....	39
4.1 Шийдвэрлэх асуудлууд .....	39
4.2 Төслөөс авсан сургамж .....	39
<b>5. Төсөл дуусгавар болохтой холбоотой санал зөвлөмж</b> .....	40
5.1 Нийтлэг шийдвэрлэх асуудлууд, зөвлөмж санал .....	40
5.2 Олон улсын татварын талаарх шийдвэрлэх асуудал, санал зөвлөмж .....	44
5.3 Татвар хураалтын талаарх шийдвэрлэх асуудлууд ба санал зөвлөмж .....	48
<b>【Хавсралт хүснэгт】</b>	
Хүснэгт 1 Төсөл хэрэгжүүлэх бүтэц.....	5
Хүснэгт 2 Хүний нөөц бэлтгэх төлөвлөгөө.....	9
Хүснэгт 3 Хамт олны хэлэлцүүлгийн үнэлгээний хуудас.....	23
Хүснэгт 4 Өр дуудах төвийн гүйцэтгэлийн мэдээлэл.....	32
Хүснэгт 5 Сургалтын ирц.....	32

Хүснэгт 6 Гадаад ажил гүйлгээний тоон үзүүлэлт.....	33
Хүснэгт 7 Гадаад ажил гүйлгээний мэдээлэл.....	36

### **【Хавсралт зураг】**

Зураг 1 Монгол Улсын төсвийн тэнцэл.....	2
Зураг 2 Татварын өр барагдуулалтын байдал.....	3
Зураг 3 ТЕГ-ын бүтэц зохион байгуулалтын зураг.....	4
Зураг 4 Татварын хуулийн шинэчилэлтийн процесс.....	18

### **【Хавсралт】**

Хавсралт 1. PDM	
Хавсралт 2. Үйл ажиллагааны урсгал зураг	
Хавсралт 3. Үйл ажиллагааны төлөвлөгөө	
Хавсралт 4. Төслийн багийн бүрэлдэхүүний ажлын гүйцэтгэл	
Хавсралт 5. Сургалтанд хамрагдагсдын мэдээлэл	
Хавсралт 6. Нийлүүлсэн тоног төхөөрөмжийн жагсаалт	
Хавсралт 7. Хамтарсан удирдах хорооны хуралдааны тэмдэглэл	

### **Нэмэлт хавсралт :Техникийн хамтын ажиллагааны үр дүнгийн нэгтгэл**

- Суурь судалгааны тайлан
- Олон улсын татвар ногдуулалттай холбоотой хүний нөөц бэлтгэх төлөвлөгөө
- Олон улсын татварын сургалтын материал, хөтөлбөр
- Олон улсын татвар ногдуулалтыг хэрэгжүүлэх бүтцийн талаарх судалгаа, дүн шинжилгээний тайлан
- Олон улсын татварын тогтолцоог бүрдүүлэхтэй холбоотой зөвлөмж
- Татварын өр барагдуулалт, шаардахтай холбоотой судалгааны тайлан
- Өр дуудах төвийн үр өгөөж, шийдвэрлэх асуудлын талаарх тайлан
- Татварын албадын дотоод ажлын талаарх судалгааны тайлан
- Татвар хураалтын гарын авлага

## Товчилсон үгс

APA	Advance Pricing Agreement	Урьдчилсан үнийн гэрээ
BEPS	Base Erosion and Profit Shifting	Татварын суурийг гажуудуулах, ашиг шилжүүлэх
CFC	Controlled Foreign Corporation	Хяналтанд байдаг гадаадын корпораци
CP	Cost Plus Method	Өртөг нэмэгдүүлэх арга
C/P	Counterpart	Хамтран ажиллагч тал
CUP	Comparable Uncontrolled Price Method	Харьцуулагдах үнийн арга
EFF	Extended Fund Facility	Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр
EOI	Exchange of Information	Мэдээлэл харилцан солилцох
GAAR	General Anti Avoidance Rule	Татвараас зайлсхийхийн эсрэг ерөнхий дүрэм
GDT	General Department of Taxation	Татварын Ерөнхий газар
IMF	International Monetary Fund	Олон Улсын Валютын сан
JCC	Joint Coordination Committee	Хамтарсан Удирдах Хороо
JICA	Japan International Cooperation Agency	Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага
MNT	Mongolian Tugrik	Төгрөг
OECD	Organization for Economic Cooperation and Development	Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа Хөгжлийн байгууллага
PE	Permanent Establishment	Төлөөний газар
PDCA	Plan Do Check Action	Төлөвлөх→Гүйцэтгэх→Үнэлэх→Сайжруулах
PDM	Project Design Matrix	Төслийн дизайн матриц
PO	Plan of Operation	Үйл ажиллагааны төлөвлөгөө
PS	Profit split method	Ашиг хуваах арга
R/D	Record of Discussion	Санамж бичиг
RP	Resale Price Method	Дамжуулан борлуулах үнийн арга
RPSM	Residual Profit Split Method	Үлдэгдэл ашиг хуваах арга
SDR	Special Drawing Rights	Татаж авах тусгай эрх
TNMM	Transactional net margin method	Ажил гүйлгээний цэвэр ашгийн арга
TP	Transfer Pricing	Үнэ шилжилт
UN	United Nations	Нэгдсэн үндэсний байгууллага



# **1. Төслийн танилцуулга**

## **1.1 Өмнөх үг**

Монгол улсын хувьд төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооноос зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжих шилжилтийн шатанд орчин цагийн татварын удирдлагын тогтолцоог бүрдүүлэхэд Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллагын (цаашид “JICA” гэх) техникийн хамтын ажиллагааны туслалцааг авсан бөгөөд арав гаран жилийн хугацаанд Монгол Улсын татвар хураалтын чадавхийг бэхжүүлэх, улсын төсөв санхүүгийн суурь болсон татварын орлогыг бүрдүүлэх, өсөн нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулах хамтын ажиллагааг хэрэгжүүлж ирсэн билээ.

2011 оны үед улсын төсвийн орлогын 82-84%-ийг татварын орлого эзэлж, адил түвшний орлого бүхий улс орнуудтай харьцуулаад, татварын орлогын бүрдүүлэлт өндөр байсан боловч, сүүлийн жилүүдэд эдийн засгийн өсөлт, хөгжилтэй зэрэгцэн шинэ асуудлууд тулгарах болсон.

Газрын нөөц баялгыг ашиглаж эхэлсэнтэй холбоотойгоор, гадаадын хөрөнгө оруулалт, үүнийг дагалдан гадаадын аж ахуйн нэгжүүд ихээр орж ирэн үйл ажиллагаа эрхлэх болсны дээр хөрш зэргэлдээ улс орнуудаас жижиг, дунд хэмжээний хөрөнгө оруулалтын хэмжээ ч өсөж, хуулийн орчны цоорхойг ашигласан татвараас зайлсхийх, үнэ шилжилтийн асуудлууд гарч эхэлсэн.

Гэвч, олон улсын татварын орчин бүрэн бүрдээгүйн дээр энэхүү асуудлыг хариуцан ажиллах мэргэжлийн ур чадвар бүхий боловсон хүчин хангалтгүй байгаагаас, олон улсын татвар ногдуулалтын хяналт шалгалт хийх, олон улсын хэлэлцээр хийх чадвар бүхий хүний нөөцийг бүрдүүлэх асуудлыг яаралтай шийдвэрлэх хэрэгцээ тулгарсан. Мөн, татварын орлого нэмэгдэхийн хамтаар өрийн хэмжээ нэмэгдэж, татварын нийт орлогын 10%-ийг эзлэх хүртлээ хуримтлагдсан байдалтай байна. Татварын өр барагдуулалтын олон талт арга хэмжээг авахын хамт, өр дуудах төв байгуулах асуудлыг авч үзэж байх үедээ өмнөх шатны төслийг хэрэгжүүлэх хүсэлтийг тавьж хэрэгжүүлсэн. Энэхүү төслийн хүрээнд олон улсын татвар ногдуулалт болон татвар хураалтын 2 салбарт хамтын ажиллагааг хэрэгжүүлсэн бөгөөд, олон улсын татварын тухайд, энэхүү салбарыг хариуцан ажиллах байцаагчид болон энгийн байцаагчдад зориулсан сургалтуудыг хийхийн зэрэгцээ, тогтолцоо бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх санал зөвлөмжийг өгсөн. Татвар хураалтын хүрээнд, бага үнийн дүнтэй өрийн барагдуулалт хийх Татварын өр дуудах төвийг байгуулах болон татвар хураалтын тогтолцоог сайжруулахтай холбоотой зөвлөмж, саналыг өгч ажилласан.

Төслийн энэ шатыг хэрэгжүүлсний дараа ч шийдвэрлэгдээгүй асуудлууд үлдсэн бөгөөд олон улсын татвар ногдуулалтын тухайд, энэхүү салбарын өндөр мэдлэг бүхий татвар төлөгчидтэй харьцахын тулд салбарын суурь мэдлэгтэй болсон байцаагчдад дунд болон ахисан түвшний мэдлэг олгох шаардлага тулгарсан бөгөөд тогтолцооны сул талуудыг сайжруулах шаардлагатай болсон. Мөн үйл ажиллагаагаа эхлүүлээд хагас жил болсон өр дуудах төвийн үйл ажиллагааг жигдрүүлэх, татвар хураалтын үйл ажиллагааны бүтээмжийг нэмэгдүүлж, татварын өр барагдуулалтыг сайжруулах шаардлага тулгарсан нөхцөл байдалд энэ шатны төслийг хэрэгжүүлэх хүсэлтийг Монголын талаас тавьсан байдаг.


## **1.2 Монгол Улсын татварын удирдлагын орчин**

Монгол Улсын эдийн засаг уул уурхайн салбарын хөгжилд тулгуурлан эрчимжиж, 2012 онд олон улсын

хөрөнгийн зах зээлд хөрөнгө босгон улс орныхоо хөгжлийг санхүүжүүлэх ажлыг хийж эхэлсэн. Гэвч, ашигт малтмалын үнэ олон улсын зах зээл дээр унасантай холбоотойгоор эдийн засгийн хүндрэлд орж, 2017 онд Олон улсын валютын сангаас дэмжлэг хүссэн бөгөөд ОУВС-аас хүсэлтийн дагуу Монгол Улсын Засгийн газартай 「Эдийн засаг, санхүүгийн бодлогын санамж бичиг」 (Memorandum of Economic and Financial Policies: MEFP) байгуулсан. Олон улсын валютын сангийн удирдах зөвлөл 5 сард 314.5 сая SDR (430 сая доллартай тэнцэх) өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийг баталсан. ОУВС-аас энэхүү хөтөлбөртэй зэрэгцүүлэн, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк болон Япон, Хятад, Солонгос зэрэг гол донор улсуудтай хамтран 5,5 тэрбум долларын багцын дэмжлэгийг бэлтгэсэн. Энэхүү санхүүгийн дэмжлэгтэйгээр Монгол Улс эдийн засгийн хүндрэлээс гарч, олон улсын итгэлийг олж эхлээд байгаа билээ.

Монгол Улсын хувьд, энэ удаагийн дэмжлэгийн хүрээнд төсвийн зарлагыг бууруулах, татварын тогтолцоог сайжруулж, төсвийн орлогын бүрдүүлэлтийг сайжруулах болон санхүү төсвийн хэмнэлтийн буюу сахилга баттай, үр өгөөжтэй удирдлагыг хэрэгжүүлэх үүрэг хариуцлагыг олон улсын өмнө хүлээсэн. Үүний үр дүнд, өнөөг хүртэл үргэлжилсэн төсвийн алдагдал 2018 онд анх удаа ашигтай гарсан ба 2019 оны эхний хагасын байдлаар төсвийн орлого 4,708.3 тэрбум төгрөг болж, төсвийн тэнцэл 192.1 тэрбум төгрөгийн ашигтай байна.

нэгж : 100 сая төгрөг



Эх үүсвэр : Үндэсний статистикийн газар

Зураг 1. Төсвийн тэнцэл

Төсвийн тэнцлийг сайжруулахтай холбоотой Олон Улсын Валютын сангаас тавьсан шаардлагад нийцүүлэх, Засгийн газрын 2016-2020 оны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, мөн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа болон дотоодын хөрөнгө оруулагчдыг бодлогоор дэмжих зорилгоор татварын багц хуулийн шинэчилэлийг УИХ-аар хэлэлцэж, төслийн зүгээс тухайн хуулийн шинэчилсэн найруулгад санал өгөх, хуулийн ажлын хэсэгтэй хамтран ажиллах шаардлага тулгарсан.

### 1.3 Төсөл хэрэгжүүлэх бүтэц бүрэлдэхүүний талаар

#### 1.3.1 Хамрагдах бүс нутаг

Тус төсөл нь Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийг (Улаанбаатар хот ба 21 аймаг, нийслэл, дүүргийн татварын албад) хамарна.



Эх үүсвэр: <https://www.cia.gov/>


Зураг 2. Төслийн хамрах бүс нутаг

#### 1.3.2 Хэрэгжүүлэгч байгууллага

Монгол Улсын Татварын Ерөнхий газар (General Department of Taxation)

Тус байгууллагын бүтэц зохион байгуулалтын зургийг 2020 оны 1 сарын байдлаар үзүүлэв.






Зураг 3. ТЕГ-ын бүтэц зохион байгуулалтын зураг

### 1.3.3 Төсөл хэрэгжүүлэх бүтэц

#### Хүснэгт 1. Төслийн бүрэлдэхүүн



\*BEPS<sup>1</sup> (Base Erosion and Profit Shifting/Татварын суурийг гажуудуулах, ашиг шилжүүлэх)

### Үр дүн 2-ын үйл ажиллагаа

Үйл ажиллагаа 2-1: Олон улсын татвартай холбоотой хяналт шалгалтын байдал ба бүтэц бүрэлдэхүүний талаар тогтсон хугацаанд судалгаа, шинжилгээ хийж, гүйцэтгэх бүтэц бүрэлдэхүүнийг сайжруулах асуудлаар зөвлөмж өгч, үр дүнг тайланд тусгана.

2018 оны 8 сард тайланг хүлээлгэн өгсөн ба үйл ажиллагааны эцсийн тайланд, Монгол Улсын ТЕГ-ын цаашид хэрэгжүүлэх асуудлуудыг тусгасан.

Үйл ажиллагаа 2-2 : Өөрийн улсын татвар ногдуулах эрхийг бүрдүүлэх, хил дамнасан татвараас зайлсхийх үйлдлээс сэргийлэх, олон улсын хэмжээнд татварын давхардал бий болгохгүй байх тогтолцоо (үнэ шилжилтийн татварын тогтолцоо), РЕ (Төлөөний газар)-д татвар ногдуулах зэрэг асуудалтай холбоотой тулгамдсан асуудлуудын талаар судалгаа, шинжилгээ хийж, тогтолцоог бүрдүүлэхтэй холбоотой зөвлөмж боловсруулах.

Олон улсын татварын тухайд, Япон Улсын туршлага, Монгол Улсын өнөөгийн нөхцөл байдалд тулгаарлан, хуулийн төсөлд холбогдох саналыг төслийн зөвлөхүүдийн зүгээс өгч ирсэн. (GAAR татвараас зайлсхийхийн эсрэг ерөнхий дүрэм) бодит үнэ тооцох арга, үнэ шилжилтийн баримжуулалт, төлөөний газар, мэдээлэл харилцан солилцох, гадаад улсад ногдуулан төлсөн татварыг төлбөл зохих татвараа хасаж тооцох журам, харилцан тохирох журам, дотоод эх үүсвэртэй орлого зэрэг бүх салбарыг хамруулсан)

Үйл ажиллагаа 2-3: Ажлын хэлэлцүүлэг (workshop) хийж, 2-1 ба 2-2-ийн судалгааны үр дүнг холбогдох талуудтай хуваалцаж, санал солилцох

ТЕГ ба Сангийн яамны хамтарсан ажлын хэсэгтэй 8 сар ба 10 сард 3 удаа ажлын хэлэлцүүлэг хийсэн ба хуулийн шинэчилэлттэй холбоотойгоор шаардлагатай бол үргэлжлүүлэн хэлэлцүүлэг хийнэ.

Үйл ажиллагаа 2-4 : Олон улсын татвар ногдуулалтын тогтолцоог бүрдүүлэхийн тухайд Япон Улсын жишээг танилцуулж, мэдээлэл өгнө (шаардлагатай бол холбогдох материалуудыг англи, монголоор орчуулах).

2018 оны 12 сард 「Японы олон улсын татварын хууль тогтоомжийн эмхэтгэл」 -ийг Монгол хэл рүү орчуулан хэвлүүлж, ТЕГ-т хүлээлгэн өгсөн ба Япон Улсын хууль тогтоомжтой харьцуулалт хийн ашиглах боломжоор хангасан.

Үйл ажиллагаа 2-5 : Гарын авлага, ашиглах материалыг боловсруулах зэргээр ТЕГ-т тогтолцоо бүрдүүлэх тал дээр дэмжлэг үзүүлэх.

---

<sup>1</sup> Орчин үеийн даяарчилгдсан бизнесийн загварын бүтцийн өөрчлөлтөөс, үндэстэн дамнасан ААН-ын үйл ажиллагааны бодит байдал ба улс орнуудын татварын тогтолцооны ялгааг ашиглан, татвар ногдох орлогыг зохиомлоор удирдан, татвараас зугтаах асуудлыг заана.

Шаардлагад нийцүүлэн Япон Улсын олон улсын татвар ногдуулалттай холбоотой хууль тогтоомж, дүрэм журам, үйл ажиллагааны хамрах хүрээ болон бодит жишээний эмхэтгэл материалыг орчуулсан. Зөвхөн орчуулах бус, ямар үндэслэл, үзэл баримтлалд тулгуурласан хуулийн заалт болох талаар тайлбар оруулж, цаашид Монгол Улсын татварын ажилтнууд өөрийн орны хууль эрх зүй, тогтолцооны өөрчлөлт шинэчилэлт хийхэд санаа авахуйц байдлаар нэгтгэн боловсруулсан. ТЕГ-ын хүсэлтийн дагуу, “ЭЗХАХБ-ын орлого ба хөрөнгийн татварын загвар конвенци”-ийн шинчилсэн найруулгыг орчуулж, хүлээлгэн өгсөн.

Үйл ажиллагаа 2-6: ТЕГ ба Сангийн яамны хооронд хийх хууль эрх зүйн орчны өөрчлөлтийн талаарх санал солилцох уулзалтад зөвлөгөө өгөх.

Нийт 4 удаагийн уулзалтын хүрээнд хуулийн төсөлд оруулах шаардлагатай асуудлаар санал өгсөн ба олон улсын татвартай холбоотой саналууд хуулийн төсөлд тусгагдан батлагдсан.

Үйл ажиллагаа 2-7: Хууль тогтоомжид байгаа асуудалтай талуудыг шүүн нэгтгэж, хамтран ажиллана. Өнөөгийн байдалд хийсэн судалгаа болон санал солилцох уулзалтуудаар дамжуулан, олон улсын татвартай холбоотой асуудлуудыг илрүүлж, хамтран ажиллагч талд танилцуулсан.

Үйл ажиллагаа 2-8 : Цаашид тогтолцоог хэрхэн бүрдүүлэх талаар холбогдох талуудтай санал солилцож, шаардлагатай зөвлөмжийг өгөх.

Хууль батлагдах хүртэл хуулийн төсөл дээр санал солилцож, зөвлөмж өгч ажилласан ба хууль батлагдсаны дараа дагалдаж гарах журмууд дээр санал зөвлөмж өгч ирсэн.

(Хууль тогтоомж УИХ-аар батлагдсан тохиолдолд хийх үйл ажиллагаа)

Үйл ажиллагааг 2-9: Татварын хуулийн өөрчлөлтийн хэрэгжилтийг хангахтай холбоотой дэмжлэг үзүүлэх (Холбогдох журам боловсруулахад дэмжлэг үзүүлэх асуудлыг оруулаад)

2020 оны 1 сараас хуулийн хэрэгжилтийг хэрхэн хангаж ажиллах тал дээр анхаарсан дэмжлэгийг үзүүлж, дагалдах журам боловсруулахад санал зөвлөмж өгөхийн хамт, Япон улсын олон улсын татвар ногдуулалт, шүүхийн шийдвэр болон бусад жишээний эмхэтгэлийг боловсруулсан.

***Үр дүн 3. Татвар хураалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх суурь бэхжинэ.***

### ***Шалгуур үзүүлэлт***

- 3.1. Татварын өр дуудах төвийн чиг үүрэг, хамруулах татварын өрийн дүнг (хамгийн зохистой байх татварын өрийн үнийн дүнгийн дээд хязгаарыг оруулаад) эргэн авч үзнэ.
- 3.2. Татвар хураалтын үйл ажиллагааг сайжруулахад зориулсан гарын авлагыг төслийн багаас ТЕГ-т хүлээлгэн өгнө.
- 3.3. (\*Гүйцэтгэлийн бие даасан эрхийг хэрэгжүүлэхэд шаардлагатай журам, (тушаал) гарын авлага боловсруулах ажлыг ТЕГ-аас хийж дуусгана)

### **Үр дүн 3-ын хүрээний үндсэн чиглэл**

- (1) Өр дуудах төвийн чиг үүргийн тухайд, энэхүү төвөөр дамжуулан дуудах нь үр дүн өндөртэй байх үнийн дүн багатай татварын өрийг цэгцлэхэд (тоо хэмжээг нэгтгэх) үйл ажиллагаагаа чиглүүлэх нь зүйтэй. Мөн дуудах татварын өрийг сонгохдоо, харилцагчтай богино хугацаанд холбогдох шаардлагатай бөгөөд өмнөх үүссэн татварын өр дээр нэмэгдэх магадлал өндөртэй татварын төрлийг түрүүлж сонгох. Эсхүл, татварын өр дуудах төвийн хүчин чадлыг тооцож, хамгийн зохистой бөгөөд барагдуулах боломжтой байх татварын өрийн дээд хязгаарыг тогтоон энэхүү сонголтыг хийх. Үүний үр дүнд, дуудлага хийсэн татварын өрийн тоо нэмэгдэх, хийсэн дуудлагаар шийдвэрлэгдсэн татварын өрийн тоо (эзлэх хувь) нэмэгдэхээр ажиллах. Өр дуудах төвийн үйл ажиллагааны үр өгөөжийг хэмжих ажлыг дахин хийсэн бөгөөд ТЕГ-аас автомат дуудлагын системийн хөгжүүлэлтийн ажлыг эхлүүлэхээр ажиллаж байгаа бөгөөд 2019 оны 12 сарын байдлаар систем ажиллаж эхлээгүй байна.
- (2) Хуулийн төсөл батлагдсаны дараа, хэрэгжилтийг хангахтай холбоотой дэмжлэг үзүүлэх талаар Хуулийн шинэчилсэн найруулга батлагдсанаар бүх асуудал шийдэгдэхгүй бөгөөд хуулийн хэрэгжилтийг хангах бүтэц бүрэлдэхүүн, орчныг бүрдүүлэх асуудал хамгаас чухлаар тавигддаг тул нэлээд хэдэн жилийн тасралтгүй дэмжлэг шаардлагатай болно. Шинэ хуульд урьд өмнө байгаагүй шинэ тогтолцоог нэвтрүүлсэн бөгөөд ТЕГ-ын ажлын хэсгийг олон удаагийн сургалт, зааварчилгаагаар хангаж ирсэн боловч, шинэ тогтолцооны талаар мэдлэг, туршлага бүхий татварын байцаагч байхгүйгээс, төвийн болон орон нутгийн нийт байцаагчдыг хамруулан сургалт зохион байгуулах, мөн татвар төлөгчдөд хуулийн талаар өргөн хүрээтэйгээр танилцуулах ажлыг богино хугацаанд хэрэгжүүлэх нь хүндрэлтэй. Иймд, цаашид хуулийн хэрэгжилтийг хангахтай холбоотойгоор хэрхэн хамтран ажиллах, төслийн зүгээс ямар дэмжлэг үзүүлэх боломжтой талаар ТЕГ-тай зөвшилцсөний үндсэн дээр ТЕГ-ын сургалтын төлөвлөгөөнд тулгуурлан улс орон даяар хэрэгжүүлэх боломжтой бүтцийг бүрдүүлэх шаардлагатай. Төсөл дуусах хүртэлх хугацаа нь шинэ хууль хүчин төгөлдөр хэрэгжиж эхлэхтэй давхцаж байгаа тул үлдсэн хугацаанд дараах асуудлууд дээр анхаарч ажиллана.
1. Татвар хураалтын шинэ тогтолцоотой холбоотой гарын авлага материал боловсруулах
  2. ТЕГ-ын удирдах ажилтан, татварын албадын хураалтын хэлтэс нэгжийн улсын ахлах байцаагчдад зориулсан сургалт
  3. Татварын албадын олон улсын татвар хариуцсан байцаагчид, татвар хураалтын байцаагчдыг удирдлага арга зүйгээр хангах
  4. Дээрх 2 сургалтын материал боловсруулах

### **Үр дүн 3-ын үйл ажиллагаа**

Үйл ажиллагаа 3-1: Үнийн дүн багатай болон үнийн дүн өндөртэй, шийдвэрлэхэд хүндрэлтэй татварын өртэй ажиллах бүтэц зохион байгуулалт, тогтолцооны өнөөгийн нөхцөл байдлыг судална (Татварын өр дуудах төвийн үйл ажиллагааны явцын асуудлыг оруулаад).

## **2. Төслийн агуулга**

Төслийн эрхэм зорилго, төслийн зорилго, зорилт, үр дүн, R/D-д заасан PDM-д тусгасан шалгуур үзүүлэлтүүдийг дараах байдлаар үзүүлэв. Эдгээр үзүүлэлтийн хэрэгжилтийг зохистойгоор хангахын тулд төслийн үйл ажиллагааг чиглүүлж ажилласан.

### **2.1 Төслийн эрхэм зорилго**

Олон улсын татвар ногдуулалт ба татвар хураалттай холбоотой татварын удирдлага улам бэхжинэ.

#### ***Шалгуур үзүүлэлт***

1. Гадаад ажил гүйлгээнд хийх татварын хяналт шалгалтаар илрүүлэх зөрчлийн хувь хэмжээ өснө.
2. Үр дүн 2 ба шалгуур үзүүлэлт 2.2-той холбоотой хууль эрх зүйн орчны бүрдүүлэлтийн хүрээнд ТЕГ-аас Сангийн яамны баримтлах чиглэлд нийцүүлэн боловсруулсан төслийг өргөн барина.
3. Татварын өр дуудах төвөөр дамжуулан хураах татварын өрийн хэмжээ буурахгүй, эсхүл өснө.
4. Гүйцэтгэлийн бие даасан эрхийн хэрэгжилтийн хүрээнд татвар хураасан тоон үзүүлэлт өснө.

### **2.2 Төслийн зорилго**

Олон улсын татвар ногдуулалт болон татвар хураалттай холбоотой татварын удирдлага бэхжинэ.

#### ***Шалгуур үзүүлэлт***

(Олон улсын татвар ногдуулалт)

1. Хамт олны хэлэлцүүлэгт гарган тавьсан ахисан түвшний кэйсийн дотроос гадаад ажил гүйлгээнд хийсэн өндөр түвшний татварын хяналт шалгалтын тоо төсөл хэрэгжиж эхлэх үетэй харьцуулаад өснө.
2. Цуглуулж хуримтлуулсан гадаад ажил гүйлгээнд хийсэн хяналт шалгалтын мэдээллийг ашиглан жишээн дээр судалгаа хийх замаар мэдлэг, туршлагаа солилцоно.
3. ТЕГ нь олон улсын татвартай холбоотой хуулийн өөрчлөлт шинэчилэлтийн саналыг Сангийн яаманд тавьж шийдвэрлүүлнэ.

(Татвар хураалт)

4. Өр дуудах төвийн үйл ажиллагаа эхлүүлэх үетэй харьцуулахад барагдуулсан өрийн тоо өснө.
5. Үйл ажиллагааны гарын авлагыг нийслэлийн бусад туршилтын дүүргүүдэд ашиглан тандалт хийнэ.
6. Гүйцэтгэлийн бие даасан эрхийн хэрэгжилттэй холбоотойгоор татварын орлого орно.

### **2.3 Гарах үр дүн ба үйл ажиллагаа (Үндсэн чиг баримтлал ба гүйцэтгэл)**

PDM-д тодорхойлсон дараах шалгуур үзүүлэлтүүдийг хангах зорилт тавьж төслийг хэрэгжүүлнэ.

***Үр дүн 1. Олон улсын татвар ногдуулалттай холбоотой дунд ба гүнзгийрүүлсэн түвшний мэдлэг, чадварыг олж авна.***

### ***Шалгуур үзүүлэлт***

- 1.1 Сургалтанд хамрагдагсдын 80% нь төлөвлөгдсөн 5 удаагийн (3 жилийн дотор) сургалтанд бүрэн хамрагдана.
- 1.2 Сургалтанд хамрагдагсдын 100%-аас дээш хувь нь сургалтын эхэнд авсан урьдчилсан шалгалтын оноотой харьцуулахад сургалтын дараах оноо нь өссөн байна.
- 1.3 Хамт олны хэлэлцүүлэгт оруулсан нийт кэйсийн талаас илүү хувь нь шалгах хуудсаар ахисан түвшний, нарийн түвэгтэй жишээний түвшинд хүрсэн байна.  
\*Хамт олны хэлэлцүүлгийн үнэлгээний жишиг болох 3.5 оноог босго болгон Олон улсын татварын ахисан түвшний, нарийн түвэгтэй жишээний түвшинд хүрсэн гэж үзнэ.

### **Үр дүн 1-ийн хүрээний үндсэн чиглэл**

Дунд ба гүнзгийрүүлсэн түвшний мэдлэг, чадварыг дараах байдлаар тогтоов.

Мэдлэгийн тал дээр өөрийн орны олон улсын татвар ногдуулалтын тогтолцоог OECD загвар гэрээний заалтууд, агуулга болон гадаад улс орнуудын адил тогтолцоотой харьцуулалт хийн, онцлог шинж чанарыг зөвөөр тодорхойлох (Дунд түвшин), олон улсын татвар ногдуулалтын хувьсан өөрчлөгдөх орчинд өөрийн орны тогтолцооны асуудалтай талыг цаг тухайд нь тодорхойлж, тухайн нөхцөл байдалд нийцсэн зохистой бөгөөд үр нөлөөтэй байх татварын тогтолцооны өөрчлөлтийн төслийг боловсруулах чадвартай байх (Гүнзгийрүүлсэн түвшин) түвшинд хүрэх зорилт тавина.

Ур чадварын тал дээр нарийн түвэгтэй үндэстэн дамнасан ажил гүйлгээ болон төв ба охин компани, төв ба салбар хооронд гэх мэт харилцан хамааралтай этгээд хоорондын ажил гүйлгээг зохистойгоор тодорхойлж, тухайлсан ажил гүйлгээн дээр татвар ногдуулалтыг зохистойгоор тодорхойлох чадвар (Дунд түвшин), улс дамнасан ажил гүйлгээний дотроос нарийн түвэгтэй, татвараас зайлсхийх өндөр түвшний тохиолдлыг зөв, зохистойгоор тодорхойлж, тухайлсан ажил гүйлгээн дээр татвар ногдуулалтыг зөв хийх чадвартай байх (Гүнзгийрүүлсэн түвшин) түвшинд хүрэх зорилт тавина.

### **Үр дүн 1-ийн үйл ажиллагаа**

Үйл ажиллагаа 1-1: Төсөлд хамруулах салбартай холбоотой өмнө нь хэрэглэж байсан сургалтын хөтөлбөр, багшийн заах арга зүйн материал, сургалтад хамрагдагсдын талаар суурь судалгаа хийнэ. Гадны байгууллагаар суурь судалгааг хийлгэсэн бөгөөд 2017 оны 6 сард тайланг хүлээлгэн өгсөн.

Үйл ажиллагаа 1-2 : Төсөл хэрэгжүүлэх хугацааны олон улсын татвар ногдуулалттай холбоотой хүний нөөцийг бэлтгэх төлөвлөгөө боловсруулна.

Суурь судалгааны үр дүн болон холбогдох талуудтай санал солилцож, Хүснэгт 2-г үзүүлсэн хүний нөөц бэлтгэх төлөвлөгөөг боловсруулсан.

Үйл ажиллагаа 1-3: 1-2-т заасан төлөвлөгөөнд үндэслэн, өмнө нь ашиглаж байсан-сургалтын хөтөлбөр, сургалтын материалд шаардлагатай өөрчлөлт оруулах.

Сургалтын хөтөлбөр, сургалтын материалыг шинээр бэлтгэсэн бөгөөд хавсралтаар үзүүлэв.

Үйл ажиллагаа 1-4 : Сургалт зохион байгуулах. (※Сургалтын өмнө сургалтанд хамрагдагсдын олон улсын татвар ногдуулалтын талаар хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны талаар суурь мэдээллийг цуглуулна.)


Төслийн хугацаанд ахисан түвшний сургалтыг 6 удаа, тусгай сургалтыг 3 удаа, гадаад сургалтыг 3 удаа хэрэгжүүлсэн.

Үйл ажиллагаа 1-5 : Сургалтын мөрөөр хийх ажлын хүрээнд гүйцэтгэлийн хэрэгжилтийн байдалд мониторинг хийх (Шаардлагаас хамаарч, зөвлөгөө өгнө)

Сургалтын мөрөөр хийх ажлын хүрээнд, сургалтаар авсан мэдлэгээ ажлын байранд хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар мониторинг хийсэн. 2018 оны 9 сар, 2019 оны 9 сард 2 удаа гүйцэтгэлийн мониторинг хийж, үр дүнг нэгтгэн тайланг хүлээлгэн өгсөн.



Хүснэгт 2. Олон улсын татвар хариуцсан байцаагчдад зориулсан сургалтын хуваарь



- Урьдчилсан сургалт: Шинээр сонгогдсон болон хуучин байцаагчдын мэдлэгийн зөрүүг арилгах зорилгоор, төслийн эхний шатны сургалтын агуулгаар, шинэ байцаагчдыг хамруулан хийх сургалт
- Ахисан түвшний сургалт: Олон улсын татвар хариуцсан байцаагчдын мэдлэгийг ахисан түвшинд дээшлүүлэх сургалт
- Тусгай сургалт: Олон улсын татварын сургалтын үр дүнг тооцох сургалт бөгөөл, Японд сургалтанд хамрагдагсдыг сонгох давхар зорилготой
- Японд хийх сургалт: Сонгогдсон байцаагчдыг хамруулан Япон улсад хийх ахисан түвшний сургалт
- Давтан сургалт: Японы сургалтанд хамрагдаагүй байцаагчдад мэдлэгийн зөрүү арилгах зорилгоор адил агуулгаар хийх сургалт
- Хамт олны хэлэлцүүлэг: Японд хийсэн сургалт болон давтан сургалтын үр дүнг нэгтгэн үнэлгээ өгөх

Үйл ажиллагаа 1-6 : Сургалтын дараа нэг жилийн дотор жишээн дээр ажиллаж, туршлага солилцох уулзалт (хамт олны хэлэлцүүлэг) хийх.

2018 оны 11 сар болон 2019 оны 11 сард 2 удаа хийсэн ба дараах асуудлуудаар сургалтанд хамрагдагсдыг 8 багт хуваан, үнэлгээ хийсэн. Төлөвлөгөөгөөр хамт олны хэлэлцүүлгийг 1 удаа хийхээр байсан боловч, суралцагсдын ахиц, дэвшлийг тодорхойлох үүднээс 2 удаа хийсэн.

1. Татвар ногдуулах үндэслэлийг зөв тодорхойлж байгаа эсэх (хяналт шалгалт хийх чадвар)
2. Холбогдох хууль эрх зүйн актыг зөв нийцүүлэн ашиглаж байгаа эсэх (дүгнэх чадвар)
3. Дүгнэлтийг зөв хийж байгаа эсэх.
4. Хүрэх ёстой дүгнэлтэд хүрч чадаагүй тохиолдолд, асуудлыг шийдвэрлэх аргыг ойлгож байгаа эсэх. (Асуудлыг шинжлэх, шийдвэрлэх чадвар)
5. Өндөр түвшний, хүндрэлтэй жишээн дээр ажиллаж чадаж байгаа эсэх.

Үйл ажиллагаа 1-7 : Үнэлгээний үр дүнг хүний нөөц бэлтгэх төлөвлөгөөнд тусган, ТЕГ-тай санал солилцох ба шаардлагатай тохиолдолд төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах.

Хамт олны хэлэлцүүлгийн тайлан, оролцогсдын ярилцлагын үр дүн дээр үндэслэн, ТУХАГ-тай санал солилцож, үнэ шилжилтийн тохируулга хийх зохистой аргыг сонгох, ашиглах талаар нэмж тусган өөрчилсөн.

***Үр дүн 2. Олон улсын татвар ногдуулалттай холбоотой үйл ажиллагааг хэрэгжүүлэх суурь улам бэхжинэ.***

### ***Шалгуур үзүүлэлт***

- 2.1. ТЕГ-ын Татварын удирдлага, хамтын ажиллагааны газар ба Эрсдэлийн удирдлагын газар гадаад ажил гүйлгээнд хийх хяналт шалгалтын мэдээллийг цуглуулж нэгтгэнэ.
- 2.2. Япон талын төслийн багаас дотоод эх үүсвэр бүхий орлоготой холбоотой эх үүсвэрийн дүрмийн төсөл, үндэстэн дамнасан татвараас зайлсхийхээс сэргийлэх тогтолцоог өргөжүүлэх, олон улсын хэмжээнд татварын давхардал бий болгохгүй байх тогтолцоог бүрдүүлэхэд чиглэгдсэн хууль эрх зүйн орчныг өөрчлөн шинэчлэхтэй холбоотой санал боловсруулна.
- 2.3. (ТЕГ-ын олон улсын татвар ногдуулалттай холбоотой үйл ажиллагаанд баримтлах журам (тушаал) гаргах)

### **Үр дүн 2-ын хүрээний үндсэн чиглэл**

Тогтолцоо ба бүтэц зохион байгуулалтын тал дээр олон улсын татвар ногдуулалтын жишиг болох OECD-ээс гаргасан BEPS-ийн зөвлөмжид нийцүүлэхийг үргэлжлүүлэн анхаарч ажиллана. Татварын хуулийн шинэчилсэн найруулгын тухайд, Олон улсын үйл ажиллагааг хэрэгжүүлэх бүтэц бүрэлдэхүүний зохистой байдлыг хангахын тулд төслийн багийн зөвлөхүүдийг оруулсан холбогдох талуудын уулзалтуудыг зохион байгуулж, хууль эрх зүйн орчныг бүрдүүлэхэд ашиглах боломжоор хангах үүднээс Японы холбогдох хууль, тогтоомжийг танилцуулах байдлаар хэрэгжүүлсэн.

2017 онд татварын өрийн байдал, татварын өр барагдуулалтын хэрэгжүүлэлтийн байдлын талаар судалгаа хийж, хойшлогдсон ба шинээр үүссэн татварын өр, татварын өрийн үлдэгдлийн талаар (татварын хэмжээгээр, үүссэнээс хойших насжилтаар ялгасан) тодорхойлсон.

Үйл ажиллагаа 3-2: Үйл ажиллагаа 3-1-ийн хүрээнд сайжруулах асуудлуудыг тодорхойлж, ажлын бүтээмж, үр дүнг сайжруулахтай холбоотой санал зөвлөмж өгнө (Үр дүнг тайлан болгон нэгтгэх).

3-1 судалгааны үр дүнд үндэслэн, энгийн татварын өр ба өндөр үнийн дүнтэй, шийдвэрлэхэд хүндрэлтэй татварын өрийг барагдуулахтай холбоотой бүтэц бүрэлдэхүүн (хэрэгжүүлэх бүтэц, татварын өр тус бүрээр авах арга хэмжээ) зэрэг бодит хэрэгжилтийн нөхцөл байдлыг тодорхойлж, үйл ажиллагааны үр нөлөөг сайжруулахтай холбоотой санал зөвлөмжийг боловсруулан 2017 оны 12 сарын 15-нд тайлан байдлаар хүлээлгэн өгсөн.

Үйл ажиллагаа 3-3: Өр дуудах төвийн үйл ажиллагааны үр өгөөжийг хэмжихэд баримтлах чиглэлийг боловсруулах.

Өр дуудах төвийн үйл ажиллагааны үр өгөөжийг хэмжихийн тухайд, тодорхой хугацаанд хийсэн дуудлагын тоо, төлбөр барагдуулах амлалтын тоо, татварын албадад буцаагдсан тохиолдлын тоог гарган, операторуудын үйл ажиллагааны нөхцөл байдал, дуудлагад хамруулах татварын төрөл, үнийн дүн, хамруулах татвар төлөгчид, дуудлага хийх хугацаа, хэдэн цагт дуудлага хийх зэрэг олон талаас нь харж хамгийн үр дүнтэй байх арга, нөхцөл байдлыг тодорхойлон шинжилж, санал зөвлөмж өгч ирсэн.

Үйл ажиллагаа 3-4: Үр өгөөжийг хэмжиж, сайжруулах асуудлуудыг тодорхойлох.

Өр дуудах төв байгуулагдсанаас хойш 3 жил 8 сар гарангийн хугацаа өнгөрсөн бөгөөд энэ хугацаанд 2017 оны 12 сар, 2018 оны 11 сар, 2019 оны 11 сард нийт 3 удаа нийт дуудлагын тоо, татвар төлөх амлалтын тоо, татварын албадад буцаагдсан татварын өрийн байдлыг тодорхойлох судалгааг хийсэн. Мөн дуудлагын операторуудын ажил байдал, дуудлагад хамруулах татварын төрөл, үнийн дүн, дуудлага хийх хугацаа зэрэг олон талаас нь харж, хамгийн үр дүнтэй байх арга, нөхцөл байдалд гүйцэтгэлийн үнэлгээ хийн, сайжруулах асуудлууд, хэрхэн шийдвэрлэх талаар зөвлөмж өгч ажилласан.

Үйл ажиллагаа 3-5: Хэмжилтийн үр дүнг өр дуудах төвд танилцуулж, үйл ажиллагааг хэрхэн сайжруулах талаар зөвлөмж өгч, хэрэгжилтийг дэмжиж ажиллах.

2016 оны 3 сараас үйл ажиллагаа эхлүүлсэн ба тогтмол хугацаанд гүйцэтгэлийг хянахын хамт, тухайн хугацаанд хамаарах дуудлагын тоонд эзлэх төлсөн татварын хэмжээ, эсхүл төлөхөөр амласан тоон хувь хэмжээ (цаашид «амлалтын хувь» гэх), мөн төлбөр хийхэд хүндрэлтэй болон утасны дугаар зөрүүтэй зэрэг шалтгаанаар татварын албадад буцаагдсан тохиолдлын эзлэх хувь хэмжээний (цаашид «буцаалтын хувь» гэх) талаар тайлан (2017.8.31-нд «Өр дуудах төвийн үйл ажиллагааны өнөөгийн байдал ба шийдвэрлэх асуудлууд»), 2017.12.15-нд «Өр дуудах төвийн үйл ажиллагааны өнөөгийн байдал ба шийдвэрлэх асуудлууд», 2018.11.30-нд «Өр дуудах төвийн үйл ажиллагааны өнөөгийн байдал ба шийдвэрлэх асуудлууд», мөн 2019.11.30-нд «Өр дуудах төвийн үйл ажиллагааны өнөөгийн байдал ба

шийдвэрлэх асуудлууд」 ) боловсруулж, төвийн үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой зөвлөмж, саналыг өгч ажилласан.

Үйл ажиллагаа 3-6: Төвийн үйл ажиллагаа, бүтэц бүрэлдэхүүнийг сайжруулахтай холбоотой хэрэгжүүлэх аливаа арга хэмжээг дэмжиж ажиллах.

2017 оны 4 сард Монгол Улсын татварын хуульд заасан татварын төрөл тус бүрийн хуулийн хугацаа, тайлангийн хугацааг тусгасан үйл ажиллагааны шинэ бодлогын чиглэлийг тодорхойлсон ба энэхүү чиглэлийг хэрэгжүүлэхтэй холбоотой зөвлөмжүүдийг өгсөн. Мөн, 2018 оны 1 сараас хойш, автоматжуулах систем хөгжүүлэлттэй холбоотой Техникийн даалгавар, функцийн нөхцөл шаардлагын талаар болон төвийн үйл ажиллагааны бүтэц бүрэлдэхүүн, сайжруулах асуудлуудын талаар зөвлөмж санал өгсөн.

Үйл ажиллагаа 3-7: Татварын албадын татвар хураалтын удирдлагын дотоод ажлын хэрэгжилтийн нөхцөл байдалд судалгаа хийн, шийдвэрлэх асуудлуудыг тодорхойлохын хамт, дотоод ажлын бүтээмжийг дээшлүүлэхтэй холбоотой санал (компьютер нийлүүлэхийг оруулаад) боловсруулж тайланд нэгтгэн ТЕГ-тай санал солилцох.

2017 оноос татвар хураалтын удирдлагын дотоод ажлын өнөөгийн байдлыг тодруулахын тулд татварын албадаар очиж, үйл ажиллагаа бүтэц зохион байгуулалт, компьютер хэрэглэлийн ашиглалтын байдлыг тодорхойлсон (2017.06.27 “Судалгааны тайлан”)

2017 оны эхэнд, татвар хураалтын удирдлагын дотоод ажлын нөхцөл байдлыг тодорхойлохын тулд татварын албад дээр ажиллаж, бүтэц зохион байгуулалт, техникийн ашиглалтын байдалд судалгаа хийн, тулгамдсан асуудлуудыг тодорхойлсон. (2017.6.27-нд 「Судалгааны тайлан」 ) Энэ судалгааны хүрээнд дотоод үйл ажиллагаанд шаардлагатай компьютерийн хангалт хүрэлцээгүй, байгаа нь хуучирч, ашиглалтын хурд буурсан болохыг тодорхойлж тайлагнасан. (2017.11.30-нд 「Татварын албадын дотоод ажлын тайлан」 )

Үйл ажиллагаа 3-8: Компьютерын худалдан авалт хийж хүлээлгэн өгөх.

2017 оны 9 сард Чингэлтэй, Сонгинохайрхан дүүргийн татварын албадад тус бүр 40 болон 32 нийт 72 компьютер хүлээлгэн өгхийн хамт үйл ажиллагааг хэрхэн сайжруулах талаар тайлан боловсруулж өгсөн.

Үйл ажиллагаа 3-9: Татвар хураалтын гарын авлага боловсруулах ажлаар дамжуулан, татвар хураалтын удирдлагын дотоод үйл ажиллагааг дэмжих

Татварын удирдлагын дотоод ажлын гарын авлагын тухайд, хуулийн шинэчилсэн найруулгыг УИХ-д өргөн барьсан зэрэг өөрчлөлтүүд гарсан тул тус шинэчилсэн найруулгын агуулга хэрхэн батлагдахаас хамаарч, дотоод ажлын агуулгад ихээхэн өөрчлөлт орохоор байсан тул, гарын авлага боловсруулах ажлыг хэсэг зогсоож, оронд нь татварын өр барагдуулалтын гарын авлагын эхийг боловсруулах ажилд орсон.

2019 оны 3 сард татварын багц хуулийн шинэчилсэн найруулга батлагдаж, татвар хураалтын хувьд,

гүйцэтгэлийн бие даасан эрх, татвар төлөх хоёрдогч эрхийн тогтолцоог нэвтрүүлэхээр ихээхэн өөрчлөлт орсон тул хэрэгжилтийг хангах хэрэгцээ шаардлагаас хамаарч, татварын хураалтын үйл ажиллагаанд зориулсан 「Татварын өр барагдуулалтын гарын авлага」 「Холбогдох маягтууд」 -ыг боловсруулан мөн оны 8 сард ТЕГ-т хүлээлгэн өгсөн.

Үйл ажиллагаа 3-10: Гарын авлагыг нийслэлийн зорилтот дүүргүүд дээр туршилтаар нэвтрүүлнэ.

Татварын Ерөнхий хууль батлагдсаны дараа, Үйл ажиллагаа 3-9-ийн явцын хяналтын хамтаар (нийлүүлсэн компьютерийн ашиглалтын байдалд хийх судалгаа) хэрэгжүүлэхээр төлөвлөж байсан боловч, хууль батлагдах үйл ажиллагаанд ихээхэн хугацаа орж, хүчин төгөлдөр болох хугацаа 2020 оны 1 сард болж өөрчлөгдсөн тул гарын авлагыг туршилтаар ашиглах хугацаа төсөл хэрэгжих явцад амжихааргүй болсон.

Үйл ажиллагаа 3-11: Үйл ажиллагааны хэрэгжилтийн нөхцөл байдлыг эргэн хянах (нийлүүлсэн компьютерийн ашиглалттай холбоотой үр нөлөөг хэмжих).

Үйл ажиллагаа 3-10-т өгүүлсэнчилэн, хэрэгжилтийн нөхцөл байдлыг эргэн хянах боломжгүй болсон тул Үйл ажиллагаа 3-9-ийн дагуу шинэчилсэн хуулийн агуулгад нийцүүлсэн гарын авлага, дагалдах маягтуудын төслийг боловсруулж, ТЕГ-т хүлээлгэн өгсөн.

Үйл ажиллагаа 3-12 : Дотоод ажлын үр ашгийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

2017 оны 10 сарын 5-нд зохион байгуулсан төслийн хамтарсан удирдах хорооны хуралдаанаар, ТЕГ-аас туршилтын 2 дүүрэг дээр зөвлөх багаас санал болгосон бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтийг авч үзэхээр шийдвэрлэсэн. (2017.12.15-нд 「Татварын албадын дотоод ажлын талаарх судалгааны тайлан」 )

< Санал зөвлөмжийн агуулга >

1. Татвар хураалтын нэгжийн үйл ажиллагааг төрөлжүүлж, энгийн татварын өр хариуцсан, барагдуулахад хүндрэлтэй татварын өр хариуцсан, автомашины албан татвар хариуцсан, мэдээлэл, судалгаа, зарлага хариуцсан 5 сегментэд хуваан, хариуцах ажилтны тоог эргэж харах
2. Татварын өр барагдуулалтын үйл ажиллагааг эрхчимжүүлэхийн тулд энгийн өр ба хүндрэлтэй өрийн нэгжид хуваан, тус бүрт ахлахыг томилж удирдуулах.
3. Хүндрэлтэй өр хариуцсан ажилтнаар туршлагатай, ур чадвар өндөртэй байцаагчдыг томилон ажиллуулах

(Хууль тогтоомж УИХ-аар батлагдсан тохиолдолд хийх үйл ажиллагаа)

Үйл ажиллагаа 3-13: Татварын хуулийн өөрчлөлтийг хэрэгжүүлэхэд шаардлагатай дүрэм журам боловсруулах, хуулийг сурталчилах ажилтай холбоотой зөвлөмж өгөх.

Татварын багц хуулийн шинэчилсэн найруулгыг батлуулахтай холбоотойгоор 2018 оноос ТЕГ-т байгуулагдсан ажлын хэсэгтэй хуулийн төсөл дээр хамтран ажилласан ба хууль батлагдсаны дараа дагалдах журмын төсөл, хуулийн хэрэгжилтийг хангах асуудлууд дээр анхаарч, шаардлагатай

дэмжлэгийг өгч ажилласан. Тодруулбал, татварын өрийг татвар төлөх үүрэгтэй хоёрдогч этгээдээс гаргуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх журмын төсөл, татварын өр төлөх хугацааг хөнгөлөх журмын төсөл, дуудлага худалдаа зохион байгуулах ба шууд гэрээгээр мөнгөн хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагааны журмын төсөл, хөрөнгө битүүмжлэх, түүнтэй холбогдох харилцааг зохицуулах журам болон маягтуудыг шинээр боловсруулан өгсөн.

Үүнтэй зэрэгцүүлэн, орон нутгийн бүсчилсэн сургалт, сумдын байцаагчдын сургалт, дүүргүүд болон том татвар төлөгч хариуцсан байцаагчдын сургалтуудаар дамжуулан татварын байцаагчдыг чадавхижуулах ажлыг хийж, төслийн зөвлөхүүдээс шинэ тогтолцооны онцлогийн талаар тайлбарлан оролцсон юм.

<Татварын ерөнхий хуульд тусгагдсан асуудлууд>


1. Татварын давуу эрх (Татварыг барьцааны эрх бүхий авлагын дараа, харин бусад авлагаас давуу эрхтэй байхаар заасан)
2. Гүйцэтгэлийн бие даасан эрх (Татварын байгууллага бие даан татварын өртэй татвар төлөгчийн хөрөнгийг битүүмжилж, дуудлага худалдаа хийн, мөнгөн хэлбэрт шилжүүлсэн хөрөнгөөс татварын өрийг барагдуулан хуваарилах эрхийг олгосон)
3. Татвар төлөх үүргийг өргөжүүлэх тогтолцоо (Татварын өртэй татвар төлөгчөөс татварын өрийг гаргуулах боломжгүй тохиолдолд, тухайн татвар төлөгчтэй тодорхой харилцаанд байх этгээдэд татвар төлөх үүргийг хүлээлгэн өрийг барагдуулах татвар төлөх хоёрдогч үүргийн тогтолцоо нэвтрүүлсэн)
4. Эрсдэлтэй татварыг урьдчилан хураах (татвар төлөх хуулийн хугацааг хүлээсэн тохиолдолд татварын өрийг хураах боломжгүй болох магадлалтай тохиолдолд, хуулийн хугацааг урагшлуулан нэхэмжлэх боломжтой тогтолцоог нэвтрүүлсэн)
5. Татвар төлөх хугацааны хөнгөлөлт (Татвар төлөгчид байгалийн гамшиг, гал усны аюул тохиолдсон, эсхүл үйл ажиллагаагаа зогсоосон зэрэг татварын өрөө төлөх боломжгүй нь тогтоогдсон үед, татвар төлөх хугацааг 1 жил (хамгийн уртдаа 2 жил хүртэл) хүртэл сунгах тогтолцоог нэвтрүүлэх)

Үйл ажиллагаа 3-14: Татвар хураалтын үйл ажиллагааг гүйцэтгэх, үр өгөөжтэй болгоход чиглэсэн ТЕГ-ын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх (Гүйцэтгэлийн бие даасан эрхийн хэрэгжилттэй холбоотой бичиг баримт, гарын авлага боловсруулах).

Татварын багц хуулийн шинэчилсэн найруулга батлагдаж, татвар хураалтын хувьд, гүйцэтгэлийн бие даасан эрх, татвар төлөх хоёрдогч эрхийн тогтолцоог нэвтрүүлэхээр ихээхэн өөрчлөлт орсон тул хэрэгжилтийг хангах хэрэгцээ шаардлагаас хамаарч, татварын хураалтын үйл ажиллагаанд зориулсан «Татварын өр барагдуулалтын гарын авлага» «Холбогдох маягтууд» -ыг боловсруулан 2019 оны 8 сард ТЕГ-г хүлээлгэн өгсөн.

Үйл ажиллагаа 3-15: Татварын тогтолцоог цаашид хэрхэн сайжруулах талаар холбогдох талуудтай санал солилцож, шаардлагатай зөвлөмжийг өгөх.

Татварын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулга батлагдсаны дараа, хуулийн хэрэгжилтийг хангах асуудал чухлаар тавигдах бөгөөд энэ удаагийн хуулийн шинэчилэлтэд оруулаагүй татварын хөөн хэлэлцэх хугацаа, татварын өр барагдуулах үйл ажиллагааг зогсоох, татварын өр барагдуулалтыг албадан гүйцэтгэх зэрэг тогтолцоонуудыг шинээр бүрдүүлэхэд шаардлагатай хуулийн орчинг хэрхэн бүрдүүлэх талаар үргэлжлүүлэн зөвлөгөө өгч ажилласан.



Зураг 4. Татварын ерөнхий хуулийн шинэчилэлтэй холбоотой үйл явц

## **2.4 Үйл ажиллагааны зорилго**

Энэхүү төсөл нь нийт Монгол Улсын нутаг дэвсгэрийг хамруулан, олон улсын татвар хариуцсан татварын албан хаагчдыг бэлтгэх, (дунд ба ахисан түвшний мэдлэг, ур чадварыг эзэмших) олон улсын татварыг хэрэгжүүлэх суурийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, мөн татвар хураалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх суурийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой. Ингэснээр, Монгол Улсын олон улсын татвар ба татвар хураалтыг хэрэгжүүлэх чадварыг бэхжүүлэхийн хамт, татварын удирдлагыг улам сайжруулахад хувь нэмрээ оруулна.

## **2.5 Төслийн хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа**

\* Дараах дугаарлалт нь ажлын урсгал, Ажлын төлөвлөгөөний дугаарлалтын дагуу бөгөөд Олон улсын татвар ногдуулалт, татвар хураалтын аль алинд нийтлэгээр хэрэглэсэн.

### **1-1 Холбогдох материал, мэдээлэл цуглуулах**

ОУВС-ын өргөтгөсөн хөтөлбөрийн талаарх мэдээллийг цуглуулсан. Мөн татварын тогтолцоо, татварын удирдлагын бодит нөхцөл байдлын талаарх мэдээллийг тодруулсан.

### **1-2 Үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл Ver.1~Ver.3 боловсруулах**

2017 оны 3 сард Ver.1, 2018 оны 9 сард Ver.2, 2019 оны 4 сард Ver.3-ийг боловсруулсан.

### **1-3 Ажлын төлөвлөгөөний төсөл Ver.1~Ver.3 боловсруулах**

2017 оны 4 сард Ver.1, 2018 оны 9 сард Ver.2, 2019 оны 6 сард Ver.3-ийг боловсруулсан.

### **1-4 Ажлын төлөвлөгөөний төсөл Ver.1-ийн тайлбар**

Суурь судалгааны үр дүнг нэгтгэн тусгасан Ver.1-ийн тайлбар танилцуулгыг 2017 оны 3 сард зохион байгуулсан.

### **1-5 Хэрэгжүүлэх бүтэц бүрэлдэхүүнийг тогтох**

1-4-тэй зэрэгцүүлэн, Хамтарсан удирдах хорооны бүрэлдэхүүн, төсөл хэрэгжүүлэх багийн талаар тодруулж, офис, төслийн үйл ажиллагаанд шаардлагатай тоног төхөөрөмж, ажлын орчныг бүрдүүлсэн.

### **1-6 Монгол Улсын олон улсын татвар ногдуулалт, татвар хураалттай холбоотой суурь судалгаа**

Суурь судалгааны тухайд хөндлөнгийн байгууллагаар гүйцэтгүүлсэн ба тайланг 2017 оны 6 сард хүлээлгэн өгсөн.

### **1-7 Ажлын төлөвлөгөөний төсөл Ver.1~Ver.3-ийн талаар хэлэлцэх, санал нэгдэх**

Төслийн хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөөний талаар ТЕГ-г танилцуулж, санал солилцон шалгуур үзүүлэлтүүд, тухайн шалгуур үзүүлэлтүүдийг цуглуулах арга, хариуцах ажилтан, төслийн зөвлөхүүд



хамтран ажиллаж, явцад нь мониторинг хийх аргыг тодорхойлсон.

Ажлын төлөвлөгөөний төсөл Ver.1, Ver.2 ба Ver.3-ийн тухайд ч төслийн 2,3 дахь жилийн хүрээнд ТЕГ-т танилцуулж, санал нэгдэн ажилласан.

### **1-8 Monitoring Sheet боловсруулах, хүлээлгэн өгөх**

Төслийн явцыг MonitoringSheet (Мониторингийн хуудас) байдлаар боловсруулан дараах агуулгыг тусгаж, заасан хугацаанд ТЕГ-тай санал солилцох замаар төслийн явцыг хамтран ажиллагч талтай хамтран хянаж ажилласан.

- a) Progress (Хэрэгжилтийн ахицийн байдал)
- b) Delay of Work Schedule and/or Problems(if any) (ажлын төлөвлөгөөний хоцрогдол/эсхүл шийдвэрлэх шаардлагатай асуудлууд (хэрэв байгаа бол))
- c) Modification of the Project Implementation Plan (Төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөөнд оруулах өөрчлөлт)
- d) Preparation of Gov.of Mongolia toward after the completion of the Project

Ver.1 2017 оны 8 сар хүлээлгэн өгсөн

Ver.2 2018 оны 2 сар хүлээлгэн өгсөн

Ver.3 2018 оны 8 сар хүлээлгэн өгсөн

Ver.4 2019 оны 2 сар хүлээлгэн өгсөн

Ver.5 2019 оны 8 сар хүлээлгэн өгсөн

Ver.6 2020 оны 1 сар хүлээлгэн өгсөн

### **1-9 Төслийн эцсийн үнэлгээнд бэлтгэх, хамтран ажиллах**

Төслийн эцсийн үнэлгээ хийгдээгүй боловч, 2019 оны 12 сард зохион байгуулсан Хамтарсан удирдах хорооны 6-р хуралдаанаар тухайн хугацаанд хийсэн бүх ажил, үүний дотроос арга барил шилжүүлсэн үр дүн, зорилгын биелэлтийн байдал, үйл ажиллагааны гүйцэтгэл, шалгуур үзүүлэлтүүдийн талаар нэгтгэн үнэлгээ өгсөн.

### **1-10 Эцсийн тайлан бэлтгэх, хүлээлгэн өгөх**

Төсөл дуусах үед төслийн эцсийн тайлан боловсруулсан ба дараах асуудлуудыг тусгасан:

- 1) Төслийн агуулга (хэрэгжүүлэх шалтгаан, зорилго, түүхэн замнал)
- 2) Үйл ажиллагааны агуулга (Ажлын урсгал зураг)
- 3) Төслийн тавьсан зорилгын биелэлтийн байдал (Эрхэм зорилго, төслийн зорилгын биелэлтийн байдал)
- 4) Төслийн хэрэгжилтийн явцад гарсан асуудлууд, шийдвэрлэсэн арга, авсан сургамж (үйл ажиллагааг хэрэгжүүлсэн арга, бүтэц бүрэлдэхүүн)
- 5) Төслийн дуусгавар болоход чиглэгдсэн санал зөвлөмж

### **Хавсралт материал**

- PDM (шалгуур үзүүлэлтийн өөрчлөлт ба суурь үзүүлэлтүүдийг тогтох)

- Үйл ажиллагааны урсгал зураг
- Төслийн үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөө
- Мэргэжилтнүүдийн томилогдон ажилласан байдал
- Сургалтанд хамрагдагсдын талаарх мэдээлэл
- Нийлүүлсэн тоног төхөөрөмжийн жагсаалт, үзүүлэлт (хүлээлцсэн актын хамт)
- Хамтарсан удирдах хорооны хуралдааны тэмдэглэл

**Нэмэлт хавсралт :** Техникийн хамтын ажиллагааны үр дүнгийн нэгтгэл

- Суурь судалгааны тайлан
- Олон улсын татвар ногдуулалттай холбоотой хүний нөөц бэлтгэх төлөвлөгөө
- Олон улсын татварын сургалтын материал, хөтөлбөр
- Олон улсын татвар ногдуулалтыг хэрэгжүүлэх бүтцийн талаарх судалгаа, дүн шинжилгээний тайлан
- Олон улсын татварын тогтолцоог бүрдүүлэхтэй холбоотой зөвлөмж
- Татварын өр барагдуулалт, шаардахтай холбоотой судалгааны тайлан
- Өр дуудах төвийн үр өгөөж, шийдвэрлэх асуудлын талаарх тайлан
- Татварын албадын дотоод ажлын талаарх судалгааны тайлан
- Татвар хураалтын гарын авлага

Япон, Монгол, Англи хэл дээрх тайланг CDR-ийн хамт хүлээлгэн өгсөн.

**Олон улсын татвар ногдуулалт**

**2-1 Хүний нөөцийг бэлтгэх төлөвлөгөө боловсруулах**

2017 оны 7 сард боловсруулж, Хүснэгт 1-д үзүүлсэн бүх сургалтуудыг хэрэгжүүлсэн.

**2-2 Сургалтын хөтөлбөр, сургалтын материал боловсруулах**

Сургалтын хөтөлбөр, сургалтын материалыг 2-1-т заасан хүний нөөц бэлтгэх төлөвлөгөөг тусган боловсруулсан. Хавсралт материалаас үзнэ үү.

**2-3 Олон улсын татвар ногдуулалтын ахисан түвшний Монгол Улсад хийх сургалтын бэлтгэл ажил, хэрэгжүүлэх**

Төслийн хугацаанд ахисан түвшний сургалтыг 6 удаа зохион байгуулсан ба Японд хийсэн сургалтын агуулгатай уялдуулсан сургалтын хөтөлбөрийн дагуу төслийн зөвлөхүүд хичээлүүдийг заасан. Мэдлэг чадавхийн тухайд, олон улсын татвар ногдуулалтын хувьсан өөрчлөгдөх орчинд өөрийн орны тогтолцооны асуудалтай талыг цаг тухайд нь тодорхойлж, тухайн нөхцөл байдалд нийцсэн зохистой бөгөөд үр нөлөөтэй байх татварын тогтолцооны өөрчлөлтийн төслийг боловсруулах чадвартай

болгохыг зорьсон. Хяналт шалгалт хийх чадавхийн тухайд, олон улсын ажил гүйлгээний дотроос, өндөр түвшний, нарийн түвэгтэй татвараас зайлсхийсэн схемийг олж, тодорхойлж, тухайлсан ажил гүйлгээний татвар ногдуулалтын талаар зохистой шийдвэр гаргах чадварыг бүрдүүлэхийг зорьсон.

Сургалтыг хийсэн хугацаа ба хамрагдагсдын тоог дараах байдлаар үзүүлэв. Сургалтын материал, хөтөлбөрийг Хавсралт 「Олон улсын татварын сургалтын хөтөлбөр, сургалтын материал」 -аас үзнэ үү.

1. 2017 оны 9 сар Олон улсын татварын ахисан түвшний сургалт (40 байцаагч)
2. 2017 оны 11 сар Олон улсын татварын тусгай сургалт (40 байцаагч)
3. 2018 оны 8 сар Олон улсын татварын ахисан түвшний сургалт (40 байцаагч)
4. 2018 оны 11 сар Олон улсын татварын тусгай сургалт, хамт олны хэлэлцүүлэг (40 байцаагч)
5. 2019 оны 8 сар Олон улсын татварын ахисан түвшний сургалт (40 байцаагч)
6. 2019 оны 11 сар Хамт олны хэлэлцүүлэг (40 байцаагч)

## **2-4 Олон улсын татвар ногдуулалтаар Япон Улсад хийх сургалтанд бэлтгэх, хэрэгжүүлэх (2 удаа)**

Сургалтыг зохион байгуулах хүртэлх хугацаанд хийгдсэн үйл ажиллагаа, олон улсын татвар ногдуулалтын нөхцөл байдлын талаар Японы ТЕГ-т тайлбарлаж, сургалтын агуулгад зохицуулалт хийнэ. Мөн сургалтанд хамрагдагчийг сонгох шалгуурыг тогтоон, Монголын талын сонгон шалгаруулалтад дэмжлэг үзүүлнэ. Сургалтын материалуудыг Япон хэлнээс Монгол хэлэнд орчуулах ажлыг хийсэн.

**Сургалтын зорилго:** Олон улсын татвар ногдуулалтын олон улсын нэгдсэн хандлагад (BEPS) нийцэх чадварыг бэхжүүлэх зорилго тавьсан. Удирдамжид зааснаар 「Олон улсын татвар ногдуулалтын хувьсан өөрчлөгдөх орчинд өөрийн орны тогтолцооны асуудалтай талыг цаг тухайд нь тодорхойлж, тухайн нөхцөл байдалд нийцсэн зохистой бөгөөд үр нөлөөтэй байх татварын тогтолцооны өөрчлөлтийн төслийг боловсруулах чадвартай байх」 -ыг эцсийн зорилгоо болгоно.

**Сургалтын онцлог:** Сэдэв<sup>2</sup> тус бүрийн агуулгад нийцүүлэн BEPS-ийн зөвлөмжийн агуулга, Япон Улсын авч буй арга хэмжээний талаар зааж, Монгол Улсын өнөөгийн байдлын талаар санал солилцож, мэдлэг чадвар олгох.

**Сургалтанд хамрагдагсад:** Олон улсын татвар хариуцсан 40 ажилтны дотроос 「Олон улсын татвар ногдуулалтын тогтолцооны санал боловсруулахад оролцох ажилтан」 болох 15 ажилтныг сонгоно.

**Сургалтанд хамруулах газар :** Японы ТЕГ-ын сургалтын төв

Эхний сургалтыг 2018 оны 4 сарын 12-оос 4 сарын 19-нд нийт 15 байцаагчийг хамруулан зохион байгуулсан. 2 дахь удаагийн сургалтыг 2019 оны 1 сарын 28-наас 2 сарын 5-ны хооронд 14 байцаагчийг хамруулан зохион байгуулсан. Сургалтанд хамрагдагсдын жагсаалтыг Хавсралт 5-д үзүүлэв.

## **2-5 Сургалтанд хамрагдагчийн ажилд мониторинг хийх**

---

<sup>2</sup> Японд хийсэн эхний сургалтын сэдэв: Япон ба Монголын олон улсын татварын жишээн дээр ажиллах 2 дахь удаагийн сургалт: “Үнэ шилжилтийн татвар”, “Үнэ шилжилтийн хяналт шалгалт”, “Олон улсын татварын орчин”, “Жишээн дээр ажиллах” гэсэн сэдвүүдээр зохион байгуулагдсан.

Эхний удаа 2018 оны 9 сард, дараагийн моинторингийг 2019 оны 9 сард хэрэгжүүлсэн. Сургалтанд хамрагдагсдаар асуулга бөглүүлж, дараа нь төслийн зөвлөхүүд байцаагчдын ажлын байранд очиж, ярилцлага хийх байдлаар зохион байгуулсан. Сургалтаар олж авсан мэдлэгээ ажлын байрандаа хэрхэн ашиглаж байгаа талаар ярилцлага хийн, бодит байдлыг тодорхойлж, мониторингийн үр дүнг тайлан байдлаан хүлээлгэн өгсөн.

## 2-6 Хамт олны хэлэлцүүлгийн бэлтгэл

2018 оны 10 сард хамт олны хэлэлцүүлэг хийхэд баримтлах чиглэлийг тодорхойлсон. Үнэлгээнд баримтлах чиглэл болон дараах үнэлгээний хуудсыг боловсруулж, хамт олны хэлэлцүүлэгт ашигласан.

Хүснэгт 3. Хамт олны хэлэлцүүлгийн үнэлгээний хуудас

кэйс	баг	1. Чанар			2. Бодит байдал		3. Шинжилгээ		4. Дүгнэлт		5 Нийт оноо	Нэгдсэн үнэлгээ дээд оноо 5 (5×1/5)
		оноо	авсан оноо (оноо×2)	Тайлбар	оноо	Тайлбар	оноо	Тайлбар	оноо	Тайлбар		
1	1											
2	2											
3	3											
4	4											
5	5											
6	6											
7	7											
8	8											
N	n											
Нийлбэр оноо												
Дундаж оноо												

【Үнэлгээний үзүүлэлтүүд】

- 1 Чанар : Өндөр түвшний хүндрэлтэй асуудал мөн эсэх. (5 шатлалаар авсан оноог 2 дахин нэмж, 10 шатлалаар үнэлсэн)
- 2 Бодит байдал : Ажил гүйцээнд татвар ногдуулах нөхцөлүүдийг бүгдийг тооцож чадаж байгаа эсэх (5 шатлалаар үнэлсэн)
- 3 Шинжилгээ : Нийлэх хуулийн болон олон улсын гэрээний заалтуудыг сонгох, тайлбарыг зохистой хийж чадаж байгаа эсэх. (5 шатлалаар үнэлсэн)
- 4 Дүгнэлт : Бодит байдалд зохих хуулийн заалтыг ашиглан, дүгнэлт хийж чадаж байгаа эсэх. Мөн шийдвэрлэхэд шаардлагатай хуулийн орчны өөрчлөлтийн талаар санал гаргаж чадаж байгаа эсэх.

【Нэгдсэн үнэлгээ】 1~4-ийг нэгтгэн, нийлбэр оноог 1/5-ээр үржүүлж 5 оноогоор үнэлсэн.

## 2-7 Хамт олны хэлэлцүүлэг хийх

2018 оны 11 сард болон 2019 оны 11 сард хэрэгжүүлсэн ба дараах асуудалд анхааран 8 багт хуваан үнэлгээ хийсэн.

1. Татвар ногдуулалт хийх нөхцөл шаардлагыг зөв тодорхойлж, үнэлгээ өгч чадаж байгаа эсэх.(Хяналт шалгалт хийх чадвар)
2. Хууль, татварын гэрээний зүйл заалтыг зөв ашиглаж, (тайлбарлаж) чадаж байгаа эсэх. (дүн шинжилгээ хийх чадвар)
3. Зохистой дүгнэлт хийж чадаж байгаа эсэх.
4. Байх ёстой дүгнэлтэд хүрч чадаагүй тохиолдолд, тулгарсан асуудал ба шийдвэрлэх арга замын талаар ойлголт байгаа эсэх. (асуудалд дүн шинжилгээ хийх чадвар, шийдвэрлэх аргыг санал болгох чадвар)
5. Өндөр түвшний, нарийн түвэгтэй асуудалтай ажиллаж байгаа эсэх.

## 2-8 Хүний нөөцийн төлөвлөгөөг сайжруулах

Хамт олны хэлэлцүүлгээр дамжуулан түвшин тогтоож, цаашдын сургалтанд анхаарах асуудлуудыг

тодорхойлж, шаардлагатай бол 2017 онд боловсруулсан сургалтын хөтөлбөр, сургалтын материалын агуулгад өөрчлөлт оруулан хэрэгжүүлнэ.

## **Олон улсын татвар ногдуулалт : Тогтолцоо**

### **2-9 Олон улсын татвартай холбоотой бүтэц бүрэлдэхүүнийг судалж, дүн шинжилгээ хийх**

Суурь судалгааны хүрээнд Монгол Улсын ТЕГ-ын олон улсын татвар ногдуулалттай холбоотой бүтэц бүрэлдэхүүнийг тодорхойлсон. Татварын удирдлага, хамтын ажиллагааны газар, Татварын хяналт шалгалт, арга зүйн газар (Статистик дүн шинжилгээ хариуцсан ажилтныг оруулаад), Эрсдэлийн удирдлагын хэлтэс, Хуулийн хэлтэс, Улсын төсвийн орлого, хяналтын газар, татварын албадаас асуулга судалгаа авч тайлан байдлаар 2018 оны 8 сард хүлээлгэн өгсөн. Төслийн эцсийн тайланд ТЕГ-ын цаашид хэрэгжүүлэх асуудлуудын талаар санал өгсөн.

### **2-10 Олон улсын татвар ногдуулалттай холбоотой шийдвэрлэх асуудлуудыг тодорхойлох**

Дараах тогтолцоонуудын талаар судалж, шийдвэрлэх асуудлуудыг тодорхойлохын хамт санал зөвлөмж боловсруулсан.

Үнэ шилжилт (TR), төлөөний газар (PE), татварын диваажин, гадаадын охин компаниас авсан ногдол ашгийг ашигт тооцохгүй байх тогтолцоо, гадаад улсад төлсөн татварын дүнг хасалт хийх тогтолцоо, нимгэн капиталжилт, хүүгээр ашиг бууруулах татварын тогтолцоо, орлогын эх үүсвэрт татвар ногдуулах, байнгын бус оршин суугчид татвар ногдуулах, гадаадын ААН-д татвар ногдуулах, олон улсын хэрэглээний татвар (НӨАТ), улс дамнан татвараас зайлсхийхээс сэргийлэх, олон улсын ажил гүйлгээний гэрээ, татварын гэрээ, дотоодын хууль тогтоомж.

### **2-11 Олон улсын татварын ажлын уулзалт (workshop) хийх**

2-10, 2-11-ийн судалгааны үр дүнг 2018 оны 8, 10 сард 3 удаагийн ажлын уулзалтаар дамжуулан танилцуулсан.

### **2-12 Олон улсын татварын тогтолцоог бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх**

Олон Улсын татварын чиглэлээр шинэ татварын хуулийн зүйл заалтын талаар хэрэгжилтийг хангах, бүтэц зохион байгуулалтын асуудал дээр зөвлөгөө өгөх ажлыг үргэлжлүүлэн хийхээр төлөвлөж байна. Мөн цаашид гарах магадлалтай бодит кэйсийн талаар Япон Улсын татварын хяналт шалгалтын бодит жишээ, шүүхийн шийдвэр гарсан тохиолдлуудыг нэгтгэн жишээний эмхэтгэл боловсруулж ТЕГ-ын албан хаагчид санаа авч хэрэглэх боломжоор хангасан.

### **2-13 Олон улсын татварын хууль тогтоомжид өгөх зөвлөгөө**

Хуулийн дагалдаж гарах журам, дүрэм боловруулах тал дээр үргэлжлүүлэн зөвлөгөө өгнө. BEPS-ийн тунхаглалд нийцүүлэн, цаашид ч татварын хуульд оруулах шаардлагатай өөрчлөлтийн талаар санал боловсруулсан.

## **2-14 Хамтран ажиллагч талтай тогтмол уулзалт хийх**

Тогтмол уулзалтыг үргэлжлүүлэн зохион байгуулж тогтмолжуулан хяналт шалгалт хийх арга, бүтэц зохион байгуулалт, тогтолцоог сайжруулахтай холбоотой зөвлөмжийг тасралтгүй өгч ажилласан.

## **3. Татвар хураалт**

### **3-1 Татвар хураалтын талаар Япон Улсад хийх сургалтад бэлтгэх, хэрэгжүүлэх**

Япон Улсад хийх сургалтыг 2017 оны 2 сарын 22-ноос 3 сарын 1-ны хооронд 15 байцаагчийг хамруулан зохион байгуулсан ба уг сургалтыг хийх болон сургалтын материалыг орчуулахад хамтран ажилласан.

### **3-2 Татварын өр барагдуулалт, өр дуудахтай холбоотой судалгаа**

Монгол Улсын татварын албаны хэмжээнд татвар хураалт хариуцсан байцаагчдын ур чадварын түвшин, өр барагдуулалтад хамруулах төлөгдөөгүй татварын талаарх мэдээллийн (тоон ба чанарын) байдалд судалгаа хийсэн.

2017 оны эцэс гэхэд бүх тайланг хүлээлгэн өгсөн. Дээрх судалгааг тогтсон хугацаанд үргэлжлүүлэн хийж, үйл ажиллагааг сайжруулахад судалгааны үр дүнг ашиглаж ажилласан.

### **3-3 Өр дуудах төвийн үйл ажиллагааны үр өгөөжийг хэмжихэд бэлтгэх, хэрэгжүүлэх**

Өр дуудах төв байгуулагдсанаас хойш 3 жил 8 сар гарангийн хугацаа өнгөрсөн бөгөөд энэ хугацаанд 2017 оны 12 сар, 2018 оны 11 сар, 2019 оны 11 сард нийт 3 удаа нийт дуудлагын тоо, татвар төлөх амлалтын тоо, татварын албадад буцаагдсан татварын өрийн байдлыг тодорхойлох судалгааг хийсэн.

Өр дуудах төвийн системийг ажиллуулж эхлүүлснээс хойших үйл ажиллагааны үр өгөөжийг хэмжихийн тулд нарийвчилсан чиглэл гарган (Операторын өр дуудах үйл ажиллагааны байдал, татварын төрлөөр, үнийн дүнгээр, хугацааны үечилэл, дуудлага хийсэн хугацаагаар ялган туршилт, дүн шинжилгээ хийх замаар хамгийн үр дүнтэй байх нөхцөлийг сонгоно) нэг жилийн хугацаанд хийсэн дуудлагын тоо, татвар төлөх амлалтын тоо, холбогдсон дуудлагын хувь хэмжээний талаар хэмжилт хийсэн. Үр өгөөжийн хэмжилтийн үр дүнд дүн шинжилгээ хийхийн хамт дуудлагын төвд танилцуулсан.

### **3-4 Өр дуудах төвийн үйл ажиллагааг сайжруулах зөвлөмж**

Дээр заасан 3-3-ын хүрээнд өр дуудах төвийн үйл ажиллагаатай холбоотой асуудлууд, сайжруулах зүйлсийг тодорхойлж, сайжруулахтай холбоотой зөвлөмж боловсруулсан. 2017 оны 8 сар, 2017 оны 12 сар, 2018 оны 11 сар, 2019 оны 11 сард 「Өр дуудах төвийн үйл ажиллагааны өнөөгийн байдал ба шийдвэрлэх асуудлууд」 -ын талаар тайлан боловсруулж өгсөн.

### **3-5 Өр дуудах төвийн үйл ажиллагааг сайжруулах зөвлөмж**

Өр дуудах төвийн үйл ажиллагаатай холбоотой асуудлууд, сайжруулах зүйлсийг тодорхойлж, сайжруулахтай холбоотой зөвлөмж боловсруулсан.

## **Татвар хураалт: Татвар хураалтын удирдлагын дотоод ажлын бүтээмжийг сайжруулах**

### **3-6 Татварын албад дээрх татвар хураалтын удирдлагын дотоод ажлын талаар судалгаа хийх**

2017 оны эхний хагаст татварын албадын дотоод ажлын нөхцөл байдлыг тодорхойлох судалгааг нийслэлийн 2 татварын алба дээр хийсэн ба бүтэц бүрэлдэхүүн, шийдвэрлэх асуудлуудыг тодорхойлон 2017 оны 6 сард тайлан байдлаар хүлээлгэн өгсөн.

### **3-7 Татвар хураалтын удирдлагын дотоод ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор компьютер нийлүүлэх**

2017 оны 9 сард, Улаанбаатар хотын Чингэлтэй ба Сонгинохайрхан дүүргийн татварын албадад тус бүр 40 ба 32 нийт 72 ширхэг компьютер хүлээлгэн өгсөн.

### **3-8 Татвар хураалтын гарын авлага боловсруулах**

Татварын удирдлагын дотоод ажлын гарын авлагын тухайд, хуулийн шинэчилсэн найруулгыг УИХ-д өргөн барьсан зэрэг өөрчлөлтүүд гарсан тул тус шинэчилсэн найруулгын агуулга хэрхэн батлагдахаас хамаарч, дотоод ажлын агуулгад ихээхэн өөрчлөлт орохоор байсан тул, гарын авлага боловсруулах ажлыг хэсэг зогсоож, оронд нь татварын өр барагдуулалтын гарын авлагын эхийг боловсруулах ажилд орсон.

2019 оны 3 сард татварын багц хуулийн шинэчилсэн найруулга батлагдаж, татвар хураалтын хувьд, гүйцэтгэлийн бие даасан эрх, татвар төлөх хоёрдогч эрхийн тогтолцоог нэвтрүүлэхээр ихээхэн өөрчлөлт орсон тул хэрэгжилтийг хангах хэрэгцээ шаардлагаас хамаарч, татварын хураалтын үйл ажиллагаанд зориулсан 「Татварын өр барагдуулалтын гарын авлага」 「Холбогдох маягтууд」 -ыг боловсруулан мөн оны 8 сард ТЕГ-т хүлээлгэн өгсөн.

### **3-9 Татвар хураалттай холбоотой гарын авлагыг турших**

Татварын Ерөнхий хууль батлагдсаны дараа, Үйл ажиллагаа 3-10-ийн явцын хяналтын хамтаар (нийлүүлсэн компьютерийн ашиглалтын байдалд хийх судалгаа) хэрэгжүүлэхээр төлөвлөж байсан боловч, хууль батлагдах үйл ажиллагаанд ихээхэн хугацаа орж, хүчин төгөлдөр болох хугацаа 2020 оны 1 сард болж өөрчлөгдсөн тул гарын авлагыг туршилтаар ашиглах хугацаа төсөл хэрэгжих явцад амжихааргүй болсон.

### **3-10 Туршилтын үр дүнг эргэн хянах**

Татварын ерөнхий хуулийн шинэчилэлтийн дараа, туршилтын үр дүнг хянахаар төлөвлөж байсан боловч, хүчин төгөлдөр болох хугацаа 2020 оны 1 сард болж өөрчлөгдсөн тул төсөл хэрэгжих явцад амжихааргүй болсон.

### **3-11 Татвар хураалтын удирдлагын дотоод ажлын бүтээмжийг сайжруулах төсөл боловсруулах**

Татвар хураалтын удирдлагын дотоод ажлын өнөөгийн байдлыг тодруулах судалгааны үр дүн дээр үндэслэн, үйл ажиллагааны бүтээмжийг сайжруулах талаар 2017 оны 11 сард “Татварын албадын

дотоод ажлын тайлан” боловсруулж хүлээлгэн өгсөн. Мөн 2018 оны 12 сар ба 2019 оны 12 сард “Татварын албаны дотоод ажлын бүтээмжийг тодорхойлох, шийдвэрлэх асуудлууд” тайланг Хамтарсан удирдах хорооны хуралдаанаар дамжуулан хүлээлгэн өгсөн.

### **3-12 Татвар хураалтын удирдлагын дотоод ажлын бүтээмжийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх**

Татвар хураалтын удирдлагын дотоод ажлын бүтээмжийг сайжруулахтай холбоотой бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтийн талаар зөвлөмж, санал өгсөн.

**Татвар хураалт: Татварын багц хуулийн төслийг УИХ-аар хуульчилагдан батлуулахтай холбоотой дэмжлэг**

### **3-13 Хуулийн өөрчлөлтийн хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх**

ТЕГ-аас гаргах журам болон гүйцэтгэлийн бие даасан эрхийн хэрэгжилттэй холбоотойгоор шинээр шаардлагатай болох татвар хураалтын гарын авлага (хөрөнгө битүүмжлэх, дуудлага худалдаа хийхтэй холбоотой аргачилал, маягт) боловсруулах, хариуцсан ажилтнуудад зориулсан сургалт хийх, хуулийн сурталчилгаа хийх үйл ажиллагааг дэмжиж ажилласан.

#### **3-13-1 Журамд өөрчлөлт оруулах**

Татварын багц хуулийн шинэчилсэн найруулгыг батлуулахтай холбоотойгоор 2018 оноос ТЕГ-т байгуулагдсан ажлын хэсэгтэй хуулийн төсөл дээр хамтран ажилласан ба хууль батлагдсаны дараа дагалдах журмын төсөл, хуулийн хэрэгжилтийг хангах асуудлууд дээр анхаарч, шаардлагатай дэмжлэгийг өгч ажилласан.

Тодруулбал, татварын өрийг татвар төлөх үүрэгтэй хоёрдогч этгээдээс гаргуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх журмын төсөл, татварын өр төлөх хугацааг хөнгөлөх журмын төсөл, дуудлага худалдаа зохион байгуулах ба шууд гэрээгээр мөнгөн хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагааны журмын төсөл, хөрөнгө битүүмжлэх, түүнтэй холбогдох харилцааг зохицуулах журам болон маягтуудыг шинээр боловсруулан өгсөн.

Үүнтэй зэрэгцүүлэн, орон нутгийн бүсчилсэн сургалт, сумдын байцаагчдын сургалт, дүүргүүд болон том татвар төлөгч хариуцсан байцаагчдын сургалтуудаар дамжуулан татварын байцаагчдыг чадавхижуулах ажлыг хийж, төслийн зөвлөхүүдээс шинэ тогтолцооны онцлогийн талаар тайлбарлан оролцсон.

#### **3-13-2 Татварын өр барагдуулалтын гарын авлага боловсруулах**

Татварын багц хуулийн шинэчилсэн найруулга батлагдаж, татвар хураалтын хувьд, гүйцэтгэлийн бие даасан эрх, татвар төлөх хоёрдогч эрхийн тогтолцоог нэвтрүүлэхээр ихээхэн өөрчлөлт орсон тул хэрэгжилтийг хангах хэрэгцээ шаардлагаас хамаарч, татварын хураалтын үйл ажиллагаанд зориулсан «Татварын өр барагдуулалтын гарын авлага» «Холбогдох маягтууд» -ыг боловсруулан мөн оны 8 сард ТЕГ-т хүлээлгэн өгсөн.



### **3-13-3 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагатай хийх зохицуулалт**

Дараах 1), 2)-ийг шинэчилэгдсэн хуулийн хүчин төгөлдөр болохтой зэрэгцүүлэн хэрэгжүүлэх санал тавьсан.

- 1) Шүүхийн шийдвэр гүйцэтгэх шатанд шилжсэн татварын өрийг хэрхэн шийдвэрлэх;
- 2) Татварын авлага бусад авлагатай (хувийн авлага ба бусад татварын авлага) давхацсан тохиолдолд хэрхэн хуваарилах.

### **3-13-4 Сурталчилгааны ажилд дэмжлэг үзүүлэх**

Татварын байгууллага нь бие даан хөрөнгийн битүүмжлэл, дуудлага худалдаа хийх болсон талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр ард иргэдэд сурталчилах, өмгөөлөгчдийн холбоо, татварын итгэмжлэгдсэн зөвлөхүүдийн холбоогоор дамжуулан сургалт, семинар хийхийг санал болгосон.

### **3-13-5 Татвар хураалтын байцаагчдад зориулсан сургалтад дэмжлэг үзүүлэх**

Татвар хураалтын шинэ тогтолцоог нэвтрүүлэхтэй холбоотойгоор, татварын өр барагдуулалтын ажлын зүй зохистойгоор шинэ арга барилаар хэрэгжүүлэхийн тулд мэргэжлийн ур чадвар болон татвар хураах шинэлэг арга барилыг эзэмшүүлэх шаардлагатай бөгөөд үүний тулд, ТЕГ-тай сургалтын хамрах хүрээ, агуулгын талаар сайтар зөвлөж, хуулийн шинэ зүйл заалтын талаарх ойлголтыг үүнтэй холбоотойгоор шаардлагатай болох ур чадвартай нэгтгэн эзэмшүүлэхийг зорьж ажиллахын хамт ТЕГ-аас зохион байгуулах сургалтуудад дэмжлэг үзүүлж ажилласан.

2019 оны 9 сарын 20, 21-ны сумдын байцаагчдад зориулсан 2 хоногийн сургалтанд шинэ хуулийн агуулгыг танилцуулахын хамт хэрэгжилтийн явцад анхаарах асуудлуудын талаар тайлбарласан. Сургалтанд нийт улсын хэмжээний сумдын 330 байцаагчид, 21 аймгийн татварын албадын дарга нар хамрагдсан.

### **3-14 Цаашдын хууль эрх зүйн шинэчилэлтэй холбоотой зөвлөмж**

Батлагдсан хуулийн хэрэгжилтийг хангах асуудал чухал боловч, энэ удаагийн хуулийн шинэчилэлд тусгагдаагүй хөөн хэлэлцэх хугацааг хаах, татварын өр барагдуулалтыг зогсоох, татварын өр барагдуулалтыг албадан гүйцэтгэх тогтолцоог нэвтрүүлэх зэрэг цаашид бүрдүүлэх шаардлагатай хууль эрх зүйн тогтолцооны талаар холбогдох талуудтай санал солилцож, шаардлагатай зөвлөмжийг өгч ажилласан.

### **3. Төслийн зорилтын биелэлтийн байдал**

Төслийн зорилгын биелэлтийн байдлын тухайд, ДАС үнэлгээний 5 үзүүлэлтийн хүрээнд тодорхойлов. Зохистой байдал: Төслийн зорилго нь төслийн өгөөж хүртэгчийн хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа эсэх, хамтран хэрэгжүүлэгч улс орны Засгийн газрын бодлого, Япон Улсын тусламжийн бодлоготой нийцэж байгаа эсэх.

Төслийн үр ашиг: Төслийн зорилго биелж, өгөөж хүртэгч болон хамрагдах нийгэмд үр ашиг өгсөн эсэх. Нөлөөлөл: Төслийн хэрэгжилтээс гарах эерэг ба сөрөг өөрчлөлтийг үнэлнэ.

Үр дүнтэй байдал: Оруулсан нөөцийг үр дүнтэй ашигласан эсэх.

Тогтвортой байдал: Төслөөс гарсан үр дүн нь төслийн дараа ч үргэлжлэх эсэхийг үнэлнэ.

#### **3.1 Төсөл хэрэгжүүлэх зохистой байдал**

Монгол Улс болон Япон Улсын бодлоготой нийцэж байгаа тул төсөл хэрэгжүүлэх зохистой байдлын үнэлгээ өндөр.

#### **Монгол Улсын бодлоготой нийцэх байдал.**

Монгол Улсын Засгийн газар, ОУВС-ын хөтөлбөрийн хүрээнд Дэлхийн банк, Азийн хөгжлийн банктай хамтран төсөв санхүүг дэмжих, эдийн засгийн өсөлтийн суурийг тавихаар зорьж байна. Төсвийн тэнцлийг ашигтай болгохтой холбоотой авах арга хэмжээний хүрээнд татварын тогтолцоог шинэчилэх замаар төсвийн орлогыг нэмэгдүүлэх шаардлага тулгарсан.

2016 онд байгуулагдсан шинэ Засгийн газрын 2016-2020 оны мөрийн хөтөлбөрийн үндсэн үзэл баримтлалын нэг болох Эдийн засгийн хүндрэлийг даван туулах бодлогын хүрээнд Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, дотоодын үйлдвэрлэл, хувийн секторыг дэмжихэд чиглэсэн татварын шинэчилэлийг тусган төлөвлөсөн байдаг ба төслийн үйл ажиллагаа энэхүү төлөвлөлттэй нийцэж байгаа болно.

#### **Япон Улсын Засгийн газрын тусламжааны бодлоготой нийцэх байдал**

Япон Улсын Засгийн газраас Монгол Улсын хөгжлийн болон стратегийн зорилтын биелэлтийг хангахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Монгол Улсад үзүүлэх тусламжийн хөтөлбөрийг 3 тэргүүлэх салбарыг сонгон боловсруулж, хэрэгжүүлж ирсэн билээ. Энэхүү төсөл нь Монгол Улсад үзүүлэх тусламжийн хөтөлбөрийн хүрээнд тавьсан дунд хугацааны зорилтуудын нэг болох 「Ашигт малтмалын нөөцийг тогтвортойгоор ашиглах, засаглалыг бэхжүүлэх」 зорилттой нийцэж байгаа ба цаашилбал, олон улсын татвар, татвар хураалт хариуцсан хүний нөөцийг бэлтгэх, тогтолцоог бүрдүүлэх асуудал нь Монгол улсын төсвийн тогтвортой байдлыг хангахад, мөн татварын орчныг бэхжүүлэх асуудал нь хувийн секторыг дэмжих, эдийн засгийн өсөлттэй холбогдох тул Япон Улсын тусламжийн бодлоготой нийцэж байгаа болно.

2017 оны 3 сард хоёр улсын Гадаад хэргийн сайд нарын гарын үсэг зурсан “Монгол, Японы стратегийн түншлэлийн дунд хугацааны хөтөлбөр” (2017-2021)-ийн хүрээнд боловсруулсан “Монгол Улсад үзүүлэх хөгжлийн хамтын ажиллагааны чиглэл” (2017 оны 12 сар) -д дээр дурьдсан дунд хугацааны

зорилтыг “Монгол Улсын Засгийн газрын эдийн засаг, санхүүгийн хүндрэлийг даван туулах, эдийн засгийн дунд хугацааны өсөлтийг хангах, макро эдийн засгийг тогтворжуулахад чиглэсэн арга хэмжээнүүд болох, төрийн санхүүгийн сахилга батыг (төсвийн орлого, зарлагын удирдлага) бэхжүүлэх хүрээнд хийгдэх төсөв санхүүгийн хяналтын чадавхийг нэмэгдүүлэх, хуулийн тогтолцоог бүрдүүлэх, санхүүгийн зах зээл, хөрөнгө оруулалт, бизнесийн орчныг сайжруулан гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, эдийн засгийг идэвхжүүлэхтэй холбоотой засаглалыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх” хэмээн тодорхойлсон байна. Төслийн үйл ажиллагаа нь төсөв, санхүүгийн хяналтын чадавхийг нэмэгдүүлэх, хуулийн тогтолцоо болон бизнесийн орчныг бүрдүүлэхтэй холбоотой авах арга хэмжээтэй нийцэж байгаа болно.

### **3.2 Төслийн үр ашиг**

Төслийн эрхэм зорилго, төслийн зорилго бүрэн биелэгдсэн тул үр ашиг талаасаа өндөр гэж үзэж байна.

**Төслийн эрхэм зорилго:** Олон улсын татвар ногдуулалт ба татвар хураалттай холбоотой татварын удирдлага улам бэхжинэ.

Олон улсын татвар ногдуулалт, татвар хураалттай холбоотой хууль тогтоомжуудын шинэчилэлттэй холбоотой биелэлтийн байдлын тухайд, хууль 2020 оны 1 сараас хүчин төгөлдөр хэрэгжиж эхлэх тул тодорхойлох боломжгүй боловч, нөлөөлөл ихтэй үр дүнд хүрч байгаа тул татварын удирдлага бэхжинэ хэмээн хүлээлттэй байна. Гадаад ажил гүйлгээнээс илрүүлсэн зөрчлийн тоо, өр дуудах төвийн гүйцэтгэлийн үзүүлэлтийн хувьд ч төсөл эхлэх үетэй харьцуулаад өсөлттэй байна.

**Төслийн зорилго:** Төслийн зорилго: Олон улсын татвар ногдуулалт болон татвар хураалттай холбоотой татварын удирдлага бэхжинэ.

(Татварын хуулийн хэрэгжилт 2020 оны 1 сараас тул татварын орлогод нөлөөлөх байдлыг тодорхойлох боломжгүй байх үзүүлэлтүүд байгаа.)

Олон улсын татвар болон татвар хураалттай холбоотой хууль эрх зүйн суурийг бүрдүүлсэн. Ялангуяа, гүйцэтгэлийн бие даасан эрхээр татварын байцаагчдын эрхийн хүрээг өргөтгөж, төсвийн орлого бүрдүүлэлтэд эерэгээр нөлөөлөх ба гадаад ажил гүйлгээтэй ажиллах чадвар, өр дуудах төвийн үйл ажиллагаагаар бага үнийн дүнтэй өр барагдуулалт сайжирч, татвар хураалт сайжирч байна.

### **Шалгуур үзүүлэлт**

#### **(Олон улсын татвар ногдуулалт)**

1. Хамт олны хэлэлцүүлэгт гарган тавьсан ахисан түвшний кэйсийн дотроос гадаад ажил гүйлгээнд хийсэн өндөр түвшний татварын хяналт шалгалтын тоо төсөл хэрэгжиж эхлэх үетэй харьцуулаад өснө.

Эхний хамт олны хэлэлцүүлгийн хувьд 2018 онд зохион байгуулсан эхний хэлэлцүүлгийн үеэр ахисан түвшний жишээ нийт 8 жишээнээс 4 байсан бол 2019 оны 11 сард зохион байгуулсан давтан хэлэлцүүлгийн үеэр нийт 8 жишээний 7 нь ахисан түвшний болж, төсөл эхлэх үетэй харьцуулаад

харьцангуй өндөр түвшний кэйс гардаг болсон.

2. Цуглуулж хуримтлуулсан гадаад ажил гүйлгээнд хийсэн хяналт шалгалтын мэдээллийг ашиглан жишээн дээр судалгаа хийх замаар мэдлэг, туршлагаа солилцоно.

Сургалтын хүрээнд гадаад ажил гүйлгээнд хамааралтай улс орнууд болон Япон Улсын кэйсийг ашиглан суралцсаны дараа Монголын бодит кэйс дээр ажилласан. Монгол Улсын бодит жишээний хувьд гадаад ажил гүйлгээтэй холбоотойгоор зөрчил гарч, маргаан таслах зөвлөл ба шүүхийн хүрээнд асуудал тавигдсан кэйсийг хамтран хэрхэн шийдвэрлэх талаар санал солилцох байдлаар суралцсан.

3. ТЕГ нь олон улсын татвартай холбоотой хуулийн өөрчлөлт шинэчилэлтийн саналыг Сангийн яаманд тавьж шийдвэрлүүлнэ.

Сангийн яаманд тавьж, эцсийн байдлаар хуульчилан батлагдаад байна.

Төслөөс хуулийн төсөл ба журмын төсөлд дараах байдлаар дэмжлэг үзүүлсэн.<sup>3</sup>

Олон улсын татвар

А Татварын ерөнхий хууль

(Үнэ шилжилтийн татварын тогтолцоотой холбоотой: TP (Transfer Pricing))

Татвараас зайлсхийхийн эсрэг ерөнхий дүрэм (GAAR : General Anti Avoidance Rule), Харилцан тохирох журам, (16-р зүйл)

Гадаад улсын эрх бүхий байгууллагатай харилцан мэдээлэл солилцох журам (18-р зүйл)

В ААНОАТ хууль

Хуулийн нэр томъёоны тодорхойлолт (Дотоод эх үүсвэртэй орлого) (4-р зүйл)

Төлөөний газар PE (Permanent Establishment) (6-р зүйл)

Хүүгээр ашиг бууруулах (нимгэн капитал) (14-р зүйл)

Гадаад улсад ногдуулан төлсөн татварыг төлбөл зохих татвараас хасаж тооцох (23-р зүйл)

Үнэ шилжилтийн тайлан (Улс бүрээрх тайлан, 27-р зүйл)

CFC(Controlled Foreign Corporation) (31-р зүйл)

#### **(Татвар хураалт)**

4. Өр дуудах төвийн үйл ажиллагаа эхлүүлэх үетэй харьцуулахад барагдуулсан өрийн тоо өснө.

Дараах байдлаар дуудлагын тоо ба өр барагдуулалтын хэмжээ аль аль нь өссөн ба төсөл хэрэгжсэн хугацааны нийт татварын өр барагдуулалтын дүн иенээр илэрхийлбэл 1,120 сая иенд хүрсэн байна.

---

<sup>3</sup> Төслийн багийн дэмжлэгийн хүрээнд, BEPS төслийн асуудлууд, тэдгээрээс сэргийлэхийн тулд авах арга хэмжээнүүдийн талаар ТЕГ-ын удирдлага, хариуцсан ажилтнуудад танилцуулж ирсэн. Үүний зэрэгцээ, Монгол Улсын татварын тогтолцооны дутагдалтай талуудыг олж илрүүлэх, дүн шинжилгээ хийх ажлуудаар дамжуулан хуулийн шинэчилсэн найруулгад тусгах зүйл заалтын талаар СЯ-ны ажлын хэсэгтэй нягт хамтран ажилласан. Үүний үр дүнд, олон улсын татварын талаарх өгсөн санал зөвлөмжийг өргөн хүрээтэйгээр тусгасан хуулийн төсөл боловсрогдож, 2019 оны 2 сарын 23-наас 3 сарын 24 хүртэл олон нийтийн хэлэлцүүлэг хийгдсэний дараа 3 сарын 22-нд УИХ-аар батлагдсан ба 2020 оны 1 сарын 1-нээс хүчин төгөлдөр болоод байна. (Ишигүрө Хидеаки, “Монгол Улсын олон улсын татвартай холбоотой татварын тогтолцооны шинэчилэлт” тайлан, 2019 оны 7 сар)

Хүснэгт 4. Өр дуудах төвийн статистик мэдээлэл

	Хүлээн авсан дуудлага ААН	Нийт өр ногдлын дүн (Сая төгрөг)	Үүнээс дуусгавар болсон ААН	Барагдуулсан өр ногдлын дүн	Нийт дуудсан дуудлагын тоо
2016.3.-2016.12.31	23,201	10,694.6	13745	6405.4	31202
2017.1.1-2017.12.31	50,389	12,215.3	31706	7458.9	39930
2018.1.1-2018.12.31	54,927	13,221.3	36461	8243.8	69665
2019.01.01-2019.09.30	42,503	9,682.4	26486	5946.3	44245
Нийт	171,020	45,813.6	108,398	28054.4	185,042

5. Үйл ажиллагааны гарын авлагыг нийслэлийн бусад туршилтын дүүргүүдэд ашиглан тандалт хийнэ. Татвар хураалтын гарын авлагын төслийг боловсруулан хүлээлгэн өгсөн ба туршилтаар хэрэгжүүлэх хугацаа байхгүй байгаагаас, эцэслэн боловсруулсан хувилбараар нийт татварын албадад хэрэгжүүлэхээр байна.
6. Гүйцэтгэлийн бие даасан эрхийн хэрэгжилттэй холбоотойгоор татварын орлого орно.)  
Хууль 2020 оны 1 сараас хүчин төгөлдөр хэрэгжих тул энэ шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг үнэлэх боломжгүй байна.

**Үр дүн 1: Олон улсын татвар ногдуулалттай холбоотой дунд ба гүнзгийрүүлсэн түвшний мэдлэг, чадварыг олж авна.**

Үр дүн 1 биелсэн.

ТЕГ-ын олон улсын татвар ногдуулалт хариуцсан 49 ажилтныг ахисан түвшний сургалтанд хамруулан бэлтгэж байна. Гадаад ажил гүйлгээний талаарх мэдээллийг систем дээр нэгтгэн, сургалтын хүрээнд эдгээр мэдээллийг харилцан солилцсон. Төсөл эхэлж байх үетэй харьцуулаад, нарийн түвэгтэй, өндөр зэрэглэлийн гадаад ажил гүйлгээний жишээ бараг байдаггүй байсантай харьцуулаад өссөн ба ойлголтын түвшин ч дээшилсэн.

**Шалгуур үзүүлэлт**

1.1 Сургалтанд хамрагдагсдын 80% нь төлөвлөгдсөн 5 удаагийн (3 жилийн дотор) сургалтанд бүрэн хамрагдана.

Давтан болон тусгай сургалтыг (төслийн эхний шатны сургалтанд хамрагдаагүй болон гадаад сургалтанд хамрагдаагүй ажилтнуудад зориулсан сургалт) оруулахгүйгээр нийт сургалтанд хамрагдагсдын 88.1% нь нийт 5 удаагийн сургалтанд хамрагдсан байна. (шалгуур үзүүлэлтэд заасан 5 удаагийн сургалтын тухайд, дээрх сургалтуудыг оруулаагүй болно) Төслийн явцад хамт олны хэлэлцүүлгийг нэмж нэг удаа зохион байгуулсан.

Хүснэгт 5. Сургалтын ирцийн байдал

	1 дэхь сургалт	2 дахь сургалт	3 дахь сургалт	4 дэхь сургалт	5 дахь сургалт	Дундаж оноо
Ирцийн хувь	90.5	95	82.5	91.6	81	88.1

1.2 Сургалтанд хамрагдагсдын 100%-аас дээш хувь нь сургалтын эхэнд авсан урьдчилсан шалгалтын оноотой харьцуулахад сургалтын дараах оноо нь өссөн байна. Биелэгдсэн.

Ажлын гэнэтийн шаардлагаар болон эрүүл мэндийн шалтгаанаар шалгалт авах тухайн өдрийн хичээлд оролцож амжилгүй сургалтын өмнөх ба сургалтын дараах шалгалтад хамрагдаж чадаагүй суралцагсдын тоо дунджаар 10% байна. Мөн, сургалтын өмнөх оноо нь сургалтанд хамрагдсаны дараах онооноос буурсан 2 суралцагч байна. (шалгалтын явцад удирдах ажилтанд дуудагдан, дундаас нь гарсан) Ийм байдлаар хүндэтгэх шалтгаанаар сургалтаас завсардсан хүмүүсийг тооцохгүй бол нийт сургалтанд хамрагдагсадын (100%) Pre-Post шалгалтын оноог харьцуулахад өссөн байдалтай байна.

1.3 Хамт олны хэлэлцүүлэгт оруулсан нийт кэйсийн талаас илүү хувь нь шалгах хуудсаар ахисан түвшний, нарийн түвэгтэй жишээний түвшинд хүрсэн байна.

Биелсэн.

Төслийн хүрээнд хамт олны хэлэлцүүлгийн үнэлгээнд үндэслэн, нарийн түвэгтэй бөгөөд өндөр түвшний кэйсийн үнэлгээг 3.5 оноо байхаар тогтоосон. Эхний хамт олны хэлэлцүүлгийн үр дүн 2.95 буюу 3.5-д хүрээгүй ба 2 дахь удаагийн хэлэлцүүлэгт ирүүлсэн кэйсийн үнэлгээ 3.58 буюу энэхүү жишигт хүрсэн байна.

**Үр дүн 2: Олон улсын татвар ногдуулалттай холбоотой үйл ажиллагааг хэрэгжүүлэх суурь улам бэхжинэ.**

Үр дүн 2 биелэгдсэн.

Олон улсын татвар хариуцсан бүтэц бүрэлдэхүүний тухайд, төслийн саналыг тусган, ТЕГ-ын ТУХАГ-аас гадна, УТОХГ-т олон улсын татварын асуудал хариуцсан нэгжийг шинээр бий болгосон. Энэхүү бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтийн дүнд, Үр дүн 1-ийн үйл ажиллагааны адилаар гадаад ажил гүйлгээний зөрчлийг бууруулахад үр дүнтэйгээр нөлөөлсөн.

## Шалгуур үзүүлэлт

2.1. ТЕГ-ын Татварын удирдлага, хамтын ажиллагааны газар ба Эрсдэлийн удирдлагын газар гадаад ажил гүйлгээнд хийх хяналт шалгалтын мэдээллийг цуглуулж нэгтгэнэ.

2017 оноос хойш гадаад ажил гүйлгээний талаарх мэдээллийг цуглуулах болж, 2019 оны 9 сарын байдлаар, 309 давтан хяналт шалгалтыг хийсэн байна.

Хүснэгт 6. Гадаад ажил гүйлгээний мэдээлэл (2019 оны 9 сарын байдлаар)

Он	Хяналт шалгалтанд хамрагдсан нийт татвар төлөгчийн тоо	Гадаад ажил гүйлгээний хяналт шалгалтанд хамрагдсан татвар төлөгчийн тоо (зөрчилтэй)
2017	4,968	68
2018	6,207	153
2019	3,567	88

2.2. Япон талын төслийн багаас дотоод эх үүсвэр бүхий орлоготой холбоотой эх үүсвэрийн дүрмийн төсөл, үндэстэн дамнасан татвараас зайлсхийхээс сэргийлэх тогтолцоог өргөжүүлэх, олон улсын хэмжээнд татварын давхардал бий болгохгүй байх тогтолцоог бүрдүүлэхэд чиглэгдсэн хууль эрх зүйн орчныг өөрчлөн шинэчлэхтэй холбоотой санал боловсруулна.

2.3. (ТЕГ-ын олон улсын татвар ногдуулалттай холбоотой үйл ажиллагаанд баримтлах журам боловсруулах)

Дагалдах журмуудын тухайд, GAAR-ын төслийг зөвлөх боловсруулж, бусад журмуудын төслийг ТЕГ-ын хариуцсан ажилтнуудын боловсруулсан төсөл дээр санал өгч ажилласан. Одоогийн байдлаар олон нийтийн хэлэлцүүлэгт оруулан эцэслэх шатанд явж байна. Дараах хуулийн төсөл, дагалдах журмын төсөлд санал өгсөн.

А Татварын ерөнхий хууль

(Үнэ шилжилтийн татварын тогтолцоотой холбоотой: TP (Transfer Pricing))

Татвараас зайлсхийхийн эсрэг ерөнхий дүрэм (GAAR : General Anti Avoidance Rule), Харилцан тохирох журам, (16-р зүйл)

Гадаад улсын эрх бүхий байгууллагатай харилцан мэдээлэл солилцох журам (18-р зүйл)

В ААНОАТ хууль

Хуулийн нэр томъёоны тодорхойлолт (Дотоод эх үүсвэртэй орлого) (4-р зүйл)

Төлөөний газар PE (Permanent Establishment) (6-р зүйл)

Хүүгээр ашиг бууруулах (нимгэн капитал) (14-р зүйл)

Гадаад улсад ногдуулан төлсөн татварыг төлбөл зохих татвараас хасаж тооцох (23-р зүйл)

Үнэ шилжилтийн тайлан (Улс бүрээрх тайлан, 27-р зүйл)

CFC(Controlled Foreign Corporation) (31-р зүйл)

Татварын багц хуулийн шинэчилэлттэй холбоотой үр дүнг тооцох боломжгүй байна.

***Үр дүн 3: Татвар хураалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх суурь бэхжинэ.***

Үр дүн 3 биелэгдсэн.

### **Шалгуур үзүүлэлт**

3.1. Татварын өр дуудах төвийн чиг үүрэг, хамруулах татварын өрийн дүнг (хамгийн зохистой байх татварын өрийн үнийн дүнгийн дээд хязгаарыг оруулаад) эргэн авч үзнэ.

Төслийн дэмжлэгтэйгээр ТЕГ-аас үйл ажиллагаанд баримтлах чиглэлдээ өөрчлөлт оруулсан 2017 оноос хойших байдлаар, татвараа төлөх амлалт өгөх хувь хэмжээ өсөхийн хамт, татварын албад руу буцаан шилжүүлэх татварын өрийн тоо буурсан байна. Өр, ногдол дуудах төвд хамаарах татварын өрийн шалгуурыг (1) шинээр үүссэн өр байх, 2) 3 татварын төрлөөрх татварын өр байх, 3) Татварын төрөл тус бүрийн өрийн үнийн дүн 1 сая төгрөгөөс доош байх гэсэн 3 үндсэн хэсэгт зааглаж өгсөн нь өр дуудах үйл ажиллагааны үр өгөөжийг нэмэгдүүлсэн. Мөн, ТЕГ болон татварын

албад хоорондын үйл ажиллагааны уялдааг хангаснаар, татварын албад руу буцаан шилжүүлэх өрийг түргэн хугацаанд шийдвэрлэх боломжтой болсон.

3.2. Татвар хураалтын үйл ажиллагааг сайжруулахад зориулсан гарын авлагыг төслийн багаас ТЕГ-т хүлээлгэн өгнө.

Татварын хууль эрх зүйн орчны өөрчлөлтөд нийцүүлэн төслийн зөвлөхийн зүгээс боловсруулсан татвар хураалтын гарын авлагыг 8 сард ТЕГ-т хүлээлгэн өгсөн бөгөөд журмын төслүүд эцэслэн батлагдсаны дараа татварын орлогын газраас эцэслэн боловсруулж байна.

3.3 Гүйцэтгэлийн бие даасан эрхийг хэрэгжүүлэхэд шаардлагатай журам, (тушаал) гарын авлага боловсруулах ажлыг ТЕГ-аас хийж дуусгана.

Төслийн зүгээс Татварын өрийг татвар төлөх үүрэгтэй хоёрдогч этгээдээс гаргуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх журмын төсөл, татварын өр төлөх хугацааг хөнгөлөх журмын төсөл, дуудлага худалдаа зохион байгуулах ба шууд гэрээгээр мөнгөн хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагааны журмын төсөл, хөрөнгө битүүмжлэх, түүнтэй холбогдох харилцааг зохицуулах журам болон маягтуудыг шинээр боловсруулан өгсөн. Татвар хураалтын гарын авлагын төслийг 2019 оны 8 сард боловсруулан хүлээлгэн өгсөн ба олон нийтийн хэлэлцүүлгийн үр дүнг тусгасан байдлаар журмын төсөл эцэслэн батлагдсаны дараа ТЕГ эцэслэн боловсруулсан.

### **3.3 Төслийн үр дүнтэй байдал**

Тус төслийн үр дүнд нөлөөлөхүйц тулгамдсан асуудал гараагүй боловч, хуулийн шинэчилэл болон улс төрийн шалтгаанаар, Монголд хийхээр төлөвлөгдсөн үйл ажиллагаа үр дүнтэй хэрэгжих боломжгүй байсан тохиолдлууд байсан. Төслийн үйл ажиллагааны хүрээнд хуулийн төслийг УИХ-аар хэлэлцүүлэх шатанд, тухайн үеийн шаардлагаас хамаарч зөвлөхүүдийг Монгол ажиллуулах шийдвэр гаргасны дараа хуралдаан хойшлогдох, хуралдахгүй байх тохиолдол гарч байсан. Мөн, хуулийн өөрчлөлтийн хамрах хүрээ өргөжсөнөөс, хамтран ажиллагч талд үзүүлэх дэмжлэгийг тасралтгүй байлгах шаардлага тулгарч, Японд хийх ажлын хэмжээ нэмэгдсэн. Үүнтэй холбоотойгоор, татварын хуулийн шинэчилсэн найруулгын хүчин төгөлдөр болох хугацаа нь төслийн дуусгавар болох хугацаатай давхацсан тул зорилтот дүүргүүд дээр туршилт хийлгүйгээр гарын авлагыг шууд ашиглаж эхэлсэн. ЛСА-ийн өнөөгийн журмаар, Японд хийхээр төлөвлөгдсөн хүн сарыг Монголд шилжүүлэн ажиллах боломжийн тал дээр уян хатан байдаг нь ажил амжилттай хийгдэх боломжийг олгосон.

### **3.4 Төслийн нөлөөлөл**

Татвар хураалтын гүйцэтгэлийг сайжруулах талаасаа нөлөөлөл өндөртэй гэж үзэж байгаа боловч, хуулийн шинэчилэлттэй холбоотой тоон үзүүлэлтийг одоогийн байдлаар тодорхойлон үнэлгээ өгөхөд эрт байна.

**Төслийн эрхэм зорилго: Олон улсын татвар ногдуулалт ба татвар хураалттай холбоотой татварын удирдлага улам бэхжинэ.**



Олон улсын татвар болон татвар хураалттай холбоотой хуулиуд 2020 оны 1 сараас хэрэгжих тул биелэлтийн байдлыг хэмжих боломжгүй юм. (Ялангуяа, шалгуур үзүүлэлт 4-ийн гүйцэтгэлийн бие даасан эрхийн хэрэгжилтийн хүрээнд татвар хураасан тоон үзүүлэлтийн өсөлтийг хэмжих боломжгүй) Татварын багц хуулийн шинэчилэлтэд шууд нөлөөлж байгаа тул нөлөөллийн түвшин өндөр байна. Эдийн засгийн болон нийгмийн нөлөөллийн тухайд, гүйцэтгэлийн бие даасан эрхийг зохистойгоор нэвтрүүлэх, хэрэгжүүлэх нь төсвийн орлого бүрдүүлэлтэд нөлөөлнө гэж үзэж байна. Мөн, хөрөнгө битүүмжлэх эрхийн тухайд, нийгэмд үзүүлэх нөлөөлөл ихтэй тул маш зохистой гүйцэтгэх, хэрэгжүүлэх шаардлагатай.

## Эрхэм зорилгын шалгуур үзүүлэлт (Олон улсын татвар)

1. Гадаад ажил гүйлгээнд хийх татварын хяналт шалгалтаар илрүүлэх зөрчлийн хувь хэмжээ өснө.

Хүснэгт 7 Гадаад ажил гүйлгээний мэдээлэл

Он	Хяналт шалгалтанд хамрагдсан нийт татвар төлөгчийн тоо	Гадаад ажил гүйлгээний хяналт шалгалтанд хамрагдсан татвар төлөгчийн тоо (зөрчилтэй)	Нийт зөрчлийн дүн	Нийт	Өрийн барагдуулалт	Барагдуулалтын хувь
2017	4968	68	43,719,721,329.6	4,680,373,740.9	869,823,026.2	18.6
2018	6207	153	2,191,523,600,031.1	328,930,967,763.3	4,268,848,918.6	1.3
2019	3567	88	103,572,201,046.8	10,851,937,460.1	1,800,150,399.4	16.6

\*Нэгж : MNT 2019 оны 9 сарын байдлаар

Нэмэлт тайлбар : 2018-аас 2019 оны өр барагдуулалтын байдал өссөн байна. Нийт иенээр илэрхийлбэл 240 сая иенийг хураасан байна. 2018 онд зөрчлийн тоо өссөн шалтгаан нь 2 том татвар төлөгчийн нөхөн татварын хэмжээ өндөрт байсантай холбоотой. А компанийн (уул уурхай) нөхөн татвар 296,000,000,000 төгрөг буюу нийт зөрчлийн үнийн дүнгийн 90%, В компанийн (банк) нөхөн татварын хэмжээ 4,000,000,000 төгрөг буюу нийт зөрчлийн үнийн дүнгийн 1.2% байсан. Эдгээрийг оруулахгүй бол 192,854,076,802 төгрөг буюу өрийн барагдуулалт 11% болох ба тухайн жилдээ өрийн барагдуулалт хийгдээгүй тохиолдолд, дараа жилд хойшлуулан хураах тул хураах татварийн үнийн дүн ба өр барагдуулалтын хувь хэмжээнд энэ нь нөлөөлнө.

2. Үр дүн 2 ба шалгуур үзүүлэлт 2.2-той холбоотой хууль эрх зүйн орчны бүрдүүлэлтийн хүрээнд ТЕГ-аас Сангийн яамны баримтлах чиглэлд нийцүүлэн боловсруулсан төслийг өргөн барина.

Олон улсын татвар

А Татварын ерөнхий хууль

(Үнэ шилжилтийн татварын тогтолцоотой холбоотой: TP (Transfer Pricing))

Татвараас зайлсхийхийн эсрэг ерөнхий дүрэм (GAAR : General Anti Avoidance Rule), Харилцан тохирох журам, (16-р зүйл)

Гадаад улсын эрх бүхий байгууллагатай харилцан мэдээлэл солилцох журам (18-р зүйл)

В ААНОАТ хууль

Хуулийн нэр томъёоны тодорхойлолт (Дотоод эх үүсвэртэй орлого) (4-р зүйл)

Төлөөний газар PE (Permanent Establishment) (6-р зүйл)

Хүүгээр ашиг бууруулах (нимгэн капитал) (14-р зүйл)

Гадаад улсад ногдуулан төлсөн татварыг төлбөл зохих татвараас хасаж тооцох (23-р зүйл)

Үнэ шилжилтийн тайлан (Улс бүрээрх тайлан, 27-р зүйл)

CFC(Controlled Foreign Corporation) (31-р зүйл)

3. Татварын өр дуудах төвөөр дамжуулан хураах татварын өрийн хэмжээ буурахгүй, эсхүл өснө.

Хүснэгт 5-д үзүүлснээр, дуудлагын тоо ба өр барагдуулалтын хэмжээ аль аль нь өссөн ба төсөл хэрэгжсэн хугацааны нийт татварын өр барагдуулалтын дүн иенээр илэрхийлбэл 1,120 сая иенд хүрсэн байна.

4. Гүйцэтгэлийн бие даасан эрхийн хэрэгжилтийн хүрээнд татвар хураасан тоон үзүүлэлт өснө.

Хэрэгжилт 2020 оны 1-р сараас эхлэх тул хэмжих боломжгүй.

### **3.5 Тогтвортой байдал**

#### ***Хууль эрх зүйн тал:***

Олон улсын татвар болон татвар хураалттай холбоотой хууль нь хэрэгжиж эхлэх тул тогтвортой байдал өндөр боловч, ялангуяа татвар хураалттай холбоотой хуулийн зүйл заалтын тухайд, ард иргэдэд шууд хамааралтай байх тул зохистойгоор хэрэгжилтийг хангах асуудал чухлаар тавигдана.

#### ***Бүтэц зохион байгуулалтын тал:***

ТЕГ нь Монгол Улсын нэг чухал байгууллага болохын хувьд цаашид ч оршин тогтнох тул төслийн хүрээнд хүрсэн үр дүнг цаашид үр дүнтэйгээр ашиглах нь мадаггүй. Татварын хуулийн шинэчилсэн найруулгын хэрэгжилтийг хангахтай холбоотой бүтэц зохион байгуулалтын талаар шийдвэрлэх асуудлууд болон авах арга хэмжээний талаар дараагийн бүлэгт дэлгэрэнгүй тусгалаа. Тогтвортой байдал талаасаа хараад, хэрэгжилтийг хангах бүтэц зохион байгуулалтыг ОУВС-ын сегментийн бодлоготой нийцүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

#### ***Санхүүгийн тал:***

Хуулийн хэрэгжилтийг практик дээр хангаж ажиллахын тулд тасралтгүй сургалтуудыг хийх шаардлагатай бөгөөд сургалтанд шаардлагатай төсвийг ТЕГ-ын жил бүрийн төсөвт тусгаж ажиллах нь зүйтэй.

#### ***Ур чадварын тал:***

Гүйцэтгэлийн бие даасан эрхийн хэрэгжилтийг хангах хүрээнд гарын авлага боловсруулах нь суурь материалаас хэтрэхгүй тул, цаашид бодит жишээнүүд гарч эхлэхтэй холбогдуулан, жишээний эмхэтгэл гаргаж, байцаагчдын ур чадварыг сайжруулахад ашиглах шаардлагатай. Олон улсын татвар болон татвар хураалтын талаар тогтвортой байдал талаасаа харсан ур чадварыг сайжруулахтай холбоотой асуудлуудыг дараагийн бүлэгт дэлгэрэнгүй тусгалаа.

### **3.6 Төслийн үр ашигтай хэрэгжүүлэхэд нөлөөлсөн хүчин зүйлс**

Хамтарсан санхүүжилтийг хэрэгжүүлж эхлүүлэх үетэй давхцан төсөл эхэлсэн бөгөөд энэхүү санхүүжилтийн нэг нөхцөл болгон тавигдсан төсвийн орлогыг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор татварын хуулийн шинэчилэлтийн ажил хурдасгагдсан. Гүйцэтгэлийн бие даасан эрх, татвар төлөх хоёрдогч үүргийг нэвтрүүлэхийн тухайд, татвараас зайлсхийхээс бүрэн сэргийлэгдээгүй хуулийн орчинтой байсан Монгол Улсын хувьд, санхүүгийн хүндрэл болон өргөтгөсөн хөтөлбөрт хамрагдаж байсан зэрэг нь хурц эсэргүүцэлтэй тулгаралгүй батлагдах хүчин зүйлсийн нэг болсон. Мөн, олон улсын татварын тухайд, EU-аас 2017 онд татвараас зайлсхийхийн эсрэг арга хэмжээнд хамтран ажилладаггүй улс орнуудын хар жагсаалтад Монгол улсыг оруулсантай холбоотойгоор, дотоодын хуульдаа өөрчлөлт оруулах, холбогдох олон талт гэрээнд нэгдэх амлалтыг Монгол улсын талаас гаргаж, 2018 онд энэхүү жагсаалтаас хасуулсан байдаг. Энэ нь Монгол Улс BEPS арга хэмжээг авах, олон улсын татвар ногдуулалтын тал дээр хүчин чармайлт гаргах хөшүүрэг болсон гэж үзэж байна. Мөн, олон жилийн турш ЛСА-ийн хамтын ажиллагааны үр өгөөжийг хүртэж ирсний хувьд, төслийн зөвлөхүүдийн санал зөвлөмжийг тусган хүлээн авдаг орчин бүрдсэн байсан нь эерэг нөлөө үзүүлсэн.

## **4. Төслийн хэрэгжилттэй холбоотой шийдвэрлэх асуудлууд ба сургамж**

### **4.1 Шийдвэрлэх асуудлууд**

Төслийн эхний төлөвлөлтийн хүрээнд, зорилтот дүүргүүд дээр татвар хураалтын дотоод ажлыг сайжруулахтай холбоотой туршилтыг хэрэгжүүлэхээр тусгасан байсан боловч, татвар хураалттай холбоотой хууль тогтоомжид ихээхэн өөрчлөлт орох болсноор, дотоод ажлын урсгалд нөлөөлөх тул хууль батлагдсаны дараа шаардлагатай гарын авлага боловсруулах, сургалт хийхээр хойшлуулсан боловч, хууль батлагдах процесс төлөвлөснөөс оройтож, туршилт хийх хугацаа байхгүй болсон. Боловсруулсан гарын авлага, сургалтыг туршилтгүйгээр дагалдах журмын дагуу хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.

Олон улсын татвар хариуцсан ажилтны анхан ба дунд шатны сургалтыг төслийн эхний шатанд хэрэгжүүлсэн бөгөөд төслийн 2-р шатны хүрээнд эхний шатанд бэлтгэсэн байцаагчдад ахисан түвшний мэдлэг олгох зорилт тавьсан. Эхний шатанд сонгогдон, анхан дунд шатанд хамрагдсан байцаагчдын тал хувь нь жирэмсний амралт, өөр ажлын байранд шилжих зэргээр солигдож, оронд нь нөхөж орсон байцаагчдад анхан дунд шатны сургалтыг төлөвлөгөөнөөс гадуур хийж, мэдлэгийн зөрүүг арилгах шаардлага тулгарсан. Түүнээс гадна, төсөлд хамруулах байцаагчдыг сонгохдоо, англи хэлний мэдлэгийн түвшин болон насны хязгаарлалтыг шалгуур болгон сонгосноос, практик агуулга бүхий бодит жишээн дээр ажиллах байдлаар зохион байгуулагдсан ахисан түвшний сургалтын явцад ажлын туршлага дээр ихээхэн ялгаа гарч ирсэн. Байцаагчдын сонголтоос хамаарч, сургалтын үр дүн өөрчлөгдөх эрсдэл байгаа нь харагдсан. Мөн улс төрийн шалтгаанаар боловсон хүчний шилжилт хөдөлгөөн их хийгддэг Монгол Улсын хувьд, бусад төрийн байгууллагатай харьцуулаад ТЕГ-ын хүний нөөцийн бодлого тогтвортой байдгийг энд тэмдэглэх нь зүйтэй.

### **4.2 Төслөөс авсан сургамж**

Татварын хуулийн шинэчилсэн найруулгыг батлуулах нь амар хялбар асуудал байгаагүй бөгөөд ТЕГ-ын боловсруулсан хуулийн төслийг Сангийн яаманд тайлбарлаж, өгсөн саналуудыг тусган дахин хүлээлгэн өгөх хүртэлх процессийн тухайд, харьцангуй хугацаа тогтоон хэрэгжүүлэх боломжтой байсан боловч, Их хурлаар хэлэлцүүлэх шатанд, чуулганы хуралдааны тов өөрчлөгдөх, улс төрийн бусад олон хүчин зүйлсийн нөлөөгөөр хугацааны хоцрогдол гарах тохиолдлууд байсан ба төслөөс төлөвлөсөн хугацаанд заасан процессийн хэрэгжилтийг хангах боломжгүй тул энэ тал дээр уян хатан байх шаардлага тулгарч, Японд хийх ажлууд, Монголд хийх ажлууд болон зөвлөхүүдийн ажлын хуваарийг тухай бүрт зохицуулах шаардлагатай болсон.

## **5. Төсөл дуусгавар болохтой холбоотой санал зөвлөмж**

### **5.1 Олон улсын татвар болон татвар хураалтын салбарт нийтлэг шийдвэрлэх асуудлууд, зөвлөмж санал**

#### **1) Хүний нөөцийг бэлтгэх, сургалтын тогтолцоо**

##### **Олон улсын татвар:**

- (1) Олон улсын татвартай холбоотой татварын хуулийн өөрчлөлтийг практик үйл ажиллагаанд буулгах ажлыг яаралтай хийх шаардлагатай. Сургалтуудыг жишээн дээр ажиллах, практик дадлага олгох хэлбэрээр зохион байгуулж, өнөөг хүртэл бэлтгэсэн боловсон хүчний чадавхийг улам дээшлүүлэх нь чухал юм.

##### Авах арга хэмжээ

Татварын багц хуулийн шинэчилэлтийн хүрээнд, өмнөх хуулийн зохицуулалтаар татвар ногдуулах боломжгүй байсан ажил гүйлгээнд татвар ногдуулах боломжтой болсноор, харагдах ажил гүйлгээний тоо хэмжээ өсөхийн зэрэгцээ, нарийн түвэгтэй, өндөр түвшний болж ирэх нь тодорхой. Шинэ хуулийн өргөн хүрээг хамарсан зүйл заалтыг хэрхэн зохистой, зөвөөр хэрэгжүүлэхээс хамаарч, гадаадын хөрөнгө оруулалтын татвараас зайлсхийх үйлдлийг хязгаарлах, хөрөнгө оруулалтын тогтвортой орчныг бүрдүүлэх нь татварын гэрээ болон олон улсын мэдээллийн сүлжээг хэрхэн зохистой ашиглахаас хамаарна.

Төслийн хүрээнд олон улсын татвар хариуцсан байцаагчдыг бэлтгэж ирсэн боловч, татварын шинэ хуулийн орчинд тоо хэмжээ өссөн, өндөр түвшний, нарийн түвэгтэй ажил гүйлгээтэй ажиллах чадварыг бэхжүүлэхийн тулд байцаагчдын ур чадварыг чанарын өндөр түвшинд гаргах, мөн олон улсын татвар хариуцсан байцаагчдын тоог өсгөх шаардлага тулгарна. Олон улсын татварын асуудлыг шийдвэрлэх чадвар бүхий хүний нөөцийг бэлтгэх, чадавхижуулахын тулд ажлын байран дахь сургалтын тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай.

1. Сургалтын төвийг бэхжүүлэх (сургалтын төвд зааж байгаа олон улсын татварын суурь сургалтыг өргөжүүлэх, жишээлбэл, олон улсын татвар хариуцсан байцаагчдаар багшлуулан энгийн бйцаагчдад сургалт хийх, дунд шатны сургалтыг өргөн хүрээнд зохион байгуулах, Японы татварын байгууллагатай адилаар байцаагчаар ажиллах→багшаар ажиллах→буцаж байцаагчаар ажиллах гэсэн сэлгээг хийж, илүү практик мэдлэгийг түгээх боломжоор хангах)
2. Жишээн дээр ажиллах (татвараас зайлсхийх схем, үнэ шилжилт, төлөөний газрын судалгаа хийх)
3. Маргааны тохиолдлуудыг эмхэтгэх (Шүүхийн шийдвэр, маргаан таслах зөвлөлийн шийдвэр), тараах
4. Татварын хяналт шалгалтын үед удирдлага арга зүйгээр хангах

##### **Татвар хураалт:**

- (1) Шинэчлэгдсэн хуулийн дагуу хураалтыг үр дүнтэй байлгахын тулд зайлшгүй сургалт зохион

байгуулах шаардлагатай бөгөөд ялангуяа гүйцэтгэлийн бие даасан эрхтэй холбоотой мэдлэг, туршлагыг хурдан хугацаанд олгох нь чухал учир дараах шатлалаар сургалтуудыг зохион байгуулж, сургалтын материалыг бэлтгэх хэрэгтэй.

#### Авах арга хэмжээ

Татварын багц хууль батлагдсаны дараа, ТЕГ-аас шинэ хуулийн зүйл заалтуудыг тайлбарлах сургалтыг нийт сумдын байцаагчид, дүүргийн болон нийслэлийн татварын албаны байцаагчид болон улсын орлого, хяналтын газрын байцаагчдыг хамруулан зохион байгуулсан бөгөөд төслийн зөвлөхүүд хуучин ба шинэ хуулийн тогтолцооны ялгааны талаар лекц тавьсан. Хуулийн шинэчилсэн найруулгын агуулгад нийцүүлж, холбогдох журмуудын төслийг боловсруулан батлуулах ажил хийгдэж байгаа ба энэхүү журмууд батлагдахын зэрэгцээ, бүтэц зохион байгуулалт батлагдахын хамт, төслийн багаас хүлээлгэн өгсөн гарын авлагын төсөл, холбогдох маягтуудыг эцэслэн боловсруулж, дараах сургалтуудыг зохион байгуулах шаардлагатай.

#### ***Нэгдүгээр шат***

- a. ТЕГ болон бусад татварын албаны хураалтын ахлах байцаагчдад (хэлтсийн дарга) хураалтын тогтолцооны шинэчлэлийг ойлгуулах сургалт
- b. Татварын албаны албадан гүйцэтгэл хийх байцаагчдад татварын өр хураах ажиллагааны үндэс, хөрөнгийн байдлыг тогтоох арга, хөрөнгө битүүмжлэх, мөнгөн хэлбэрт шилжүүлэх, шилжүүлсэн орлогыг хуваарилах, татвар төлөх үүрэгтэй хоёрдогч этгээдээс татварын өрийг гаргуулах, татварын хугацааны хөнгөлөлт үзүүлэх тухай практик сургалтыг зохион байгуулах хэрэгтэй.

#### ***Хоёрдугаар шат***

Шинэчлэгдсэн татварын хуулийн мэдлэг, ур чадварыг хурдан хугацаанд олгохын тулд татварын албаны нийт байцаагчдыг ТЕГ-ын сургалт, бүсийн сургалт, татварын албаны сургалтуудад анхан, дунд, ахисан түвшинд хуваан хамруулах хэрэгтэй.

#### ***Гуравдугаар шат***

Шинэ тогтолцооны хэрэгжилтийн байдлыг харж болохоор хугацаа буюу ойролцоогоор 2 жил өнгөрсний дараа илүү мэргэжлийн өндөр ур чадвар (жишээ нь: битүүмжилсэн хөрөнгийн үнэлгээний аргачлал, хүндрэлтэй татварын өрийг хураах арга г.м) олгох сургалтуудыг зохион байгуулах хэрэгтэй.

## **2) Хуулийн хэрэгжилтийг хангах бүтэц бүрэлдэхүүнийг бүрдүүлэх**

### **Олон улсын татвар:**

- (1) Банкинд олон улсын болон дотоодын татварын хяналт шалгалт хэрэгцээ шаардлага  
Татварын хяналт шалгалтын байцаагчийн ажил үүргийн тухайд, татвар хураалт, ногдуулалтыг зэрэгцүүлэн хийдэг байсан бүтцийг өөрчилсөн нь сайн болсон боловч, дотоодын хяналт

шалгалтын хүрээнд хамгийн чухал болох банкны хяналт шалгалтын тухайд, хуулийн орчин бүрдсэн байхад хийгдэхгүй байгаа тал байна.

Авах арга хэмжээ

Олон улсын хэмжээний мөнгөн урсгал, татвараас зайлсхийхээс сэргхийлэхийн тулд, банкны судалгаа, хяналт шалгалтыг нэвтрүүлэх талаар авч үзэх хэрэгтэй.

- (2) Бусад улс орны татвар ногдуулалтын жишээн дээр судалгаа хийх

Япон Улсын хувьд, олон улсын татварын талаар хөгжингүй түвшинд хүрсэн АНУ-ын үнэ шилжилтээс суралцаж, судалсан нь ихээхэн хувь нэмрээ өгсөн.

Авах арга хэмжээ

